



**САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ДЭЭД СУРГУУЛЬ**  
**ӨДРИЙН ХӨТӨЛБӨР**  
**САНХҮҮГИЙН УДИРДЛАГЫН ТЭНХИМ**

**Жалайр**  
**Хүрэлийн НОМИНЧИМЭГ**

**ББСБ-ААР ДАМЖУУЛАН “НОГООН ЗЭЭЛ”-ИЙН**  
**ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ АРГА ЗАМ**



Мэргэжлийн индекс  
D041201

Бизнесийн удирдлагын бакалаврын  
зэрэг горилсон  
**Дипломын төсөл**

Удирдсан  
Г.Намужин/МВА/

Улаанбаатар 2023



**САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ДЭЭД**  
**СУРГУУЛЬ**  
**САНХҮҮГИЙН УДИРДЛАГЫН ТЭНХИМ**



**Жалайр**  
**Хүрэлийн НОМИНЧИМЭГ**

**ББСБ-ААР ДАМЖУУЛАН “НОГООН ЗЭЭЛ”-**  
**ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ**

**В** Мэргэжлийн индекс  
041201

**Бизнесийн Удирдлагын Бакалаврын Зэрэг**  
**Горилсон Дипломын Төсөл**

Удирдагч: ..... Г.Намужин /МВА/

Шүүмжлэгч: ..... Я.Дагшил /МВА/

Шүүмжлэгч: ..... Э.Тамир

**ГАРЧГИЙН ТОВЬЁОГ**

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ .....	ii
ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ .....	ii
ГРАФИКАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ.....	ii
ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ .....	iii
ТОВЧИЛСОН ҮГС, НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР .....	iii
ТОВЧ ХУРААНГУЙ.....	iv
ОРШИЛ.....	1
I БҮЛЭГ. Сэдвийн судлагдсан байдлын тойм .....	2
1.1 Гадаадад судлагдсан байдал .....	2
1.2 Дотоодод судлагдсан байдал .....	3
1.3 Бүлгийн дүгнэлт.....	4
II БҮЛЭГ. Онолын судалгаа.....	5
2.1 Банк бус санхүүгийн байгууллагийн тухай.....	5
2.1.1 Банк бус санхүүгийн байгууллага гэж юу вэ?.....	5
2.2 Зээлийн тухай.....	6
2.2.1 Зээлийн гэж юу вэ? .....	6
2.2.2 Ногоон зээл .....	10
2.2.3 Ногоон бонд .....	12
2.3 БҮЛГИЙН ДҮГНЭЛТ .....	14
III БҮЛЭГ. Өнөөгийн байдал .....	15
3.1 Банк бус санхүүгийн байгууллагийн өнөөгийн байдал.....	15
3.2 Ногоон зээлийн өнөөгийн байдал .....	23
3.2.1 Олон улсын ногоон зах зээлийн өнөөгийн байдал .....	23
3.2.2 Монгол улсын ногоон зээлийн өнөөгийн байдал .....	25
3.3 Бүлгийн дүгнэлт.....	29
IV БҮЛЭГ. Шинжилгээний хэсэг.....	30
4.1 Яагаад Монгол улсад ногоон зээл, ногоон санхүүжилт шаардлагатай вэ? .....	30
4.2 Монгол улсын эрчим хүчний өнөөгийн байдал .....	32
4.3 Сэргээгдэх эрчим хүчинд санхүүжилт хэрэгтэй шалтгаан: .....	32
4.4 Олон улсад ББСБ-ийн ногоон зээлийн нөхцөл болон тавигдах шаардлага .....	34
4.5 Монгол дахь ББСБ-ийн ногоон зээлийн судалгаа .....	35
4.6 Ногоон зээлийн гадаад эх үүсвэрүүд (Сэргээгдэх эрчим хүч) .....	36
4.7 Банкны ногоон зээлийг ББСБ-тай харьцуулах.....	38
4.8 Хууль зүйн зохицуулалт.....	40
4.9 ББСБ бичил байгууллага болон иргэдэд санал болгож болох бүтээгдэхүүний жагсаалт: .....	41
V БҮЛЭГ. ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ .....	42

VI БҮЛЭГ. Ном зүй.....	45
Хавсралт.....	47

## ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1 ББСБ-ын тоон мэдээлэл .....	15
Хүснэгт 2 ББСБ-ын үйл ажиллагааны төрлүүд .....	16
Хүснэгт 3 Активын үзүүлэлтүүд /сая.₮/.....	17
Хүснэгт 4 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц /сая.₮/ .....	18
Хүснэгт 5 Факторингийн тооцооны авлагын ангилал /сая.₮/ .....	19
Хүснэгт 6 ӨБҮХХ болон ӨБХ-ийн бүтэц /сая.₮/.....	19
Хүснэгт 7 Зээлийн бүтэц.....	19
Хүснэгт 8 Олгосон болон төлөгдсөн зээл салбарын ангилал /сая.₮/.....	20
Хүснэгт 9 Зээлийн ангилал.....	21
Хүснэгт 10 Бусад хөрөнгийн бүтэц /сая.₮/ .....	22
Хүснэгт 11 Ногоон зээлийг хамгийн их хэрэглэдэг 5 салбар.....	23
Хүснэгт 12 2015-2020 оны хоорондох Ногоон зээлийн бүсийн тархалт	<b>Error! Bookmark not defined.</b>
Хүснэгт 13 ББСБ-ны Ногоон зээлийн тайлан /сая төгрөгөөр/ .....	28
Хүснэгт 14 Ногоон зээлийн нөхцөл (Камбож улс).....	34

## ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Зураг 1 Зээлийн ангилал .....	7
Зураг 2 Тогтвортой хөгжлийн зорилгууд.....	9
Зураг 3 Ногоон болон энгийн бондны өсөлтийн тоо хэмжээ.....	13
Зураг 4 Ногоон бондны зах зээлийн хэмжээ.....	13
Зураг 5 Ногоон зээлийн бүтээгдэхүүний зээлийн тоогоор.....	26
Зураг 6 Ногоон зээлийн багцын чанар /ногоон таксономийн 8 ангилалаар/ .....	28
Зураг 7 Монгол улсын эрчим хүчний системийн мэдээ .....	32
Зураг 8 Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх чадварын харьцаа Монгол болон АНУ .....	32
Зураг 9 Говь цөлийн байршил .....	33
Зураг 10 2030 он гэхэд хүрэх олон улсын амлалт .....	36

## ГРАФИКАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

График 1 Сүүлийн 5 жилийн активын үзүүлэлт /тэрбум ₮/ .....	17
График 2 Сүүлийн 5 жилийн байдлаар мөнгөн хөрөнгийн бүтэц /тэрбум ₮/ .....	18

График 3 Зээлийн багцын чанар /тэрбум ₮/.....	20
График 4 Олгосон зээл /хугацаагаар/ .....	20
График 5 Ногоон зээлийн багцын чанар /ногоон таксономийн 8 ангиллаар/ .....	21
График 6 Ашигт ажилгааны үзүүлэлт /тэрбум ₮/ .....	22

## **ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ**

Хавсралт 1 Тогтвортой санхүүжилтийн холбооны түүхэн замнал.....	47
---	----

## **ТОВЧИЛСОН ҮГС, НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР**

- ББСБ – Банк бус санхүүгийн байгууллага
- ОББҮХ – Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо
- НҮБ -Нэгдсэн үндэсний байгууллага
- БСБ – Бичил санхүүгийн байгууллага
- СХЗ санхүүгийн зохицуулах хороо
- ТХЗ тогтвортой хөгжлийн зорилго
- ББС – Банк бус санхүү
- МХ- мөнгөн хөрөнгө
- ААН- Аж ахуйн нэгж
- GLP - Green loan principles (Ногоон зээлийн зарчим)

## **ТОВЧ ХУРААНГУЙ**

**Сэдвийн нэр:** ББСБ-аар дамжуулан “Ногоон зээл”-ийн хүртээмжийг нэмэгдүүлэх арга зам

**Товч танилцуулга:** Ногоон зээлийн зах зээл дэлхий дахинаа маш хурдацтай өссөн хөгжиж ногоон бизнесийг ихээр дэмжих болсон. Олон улсад нэвтрээд аль хэдийнээ үр дүнгээ өгсөн ба манай оронд нэвтрээд багагүй хугацаа өнгөрсөн байна. Манай орны нийт зээлийн 1.2 хувийг эзэлж байна. Ногоон зээл нь иргэн болон аж ахуй нэгжид жилийн 8-9 хувийн хүүтэй байх ба БОАЖЯ-наас тус зээлийн эх үүсвэрт зориулж гурван тэрбум төгрөгийн санхүүжилтийг Хас банканд 1.8 тэрбум, Хаан банканд 800 сая, Төрийн банканд 400 сая төгрөгийг 2019 оны 8-р сард төсвөөс олгон шилжүүлсэн байна. Гэсэн хэдий үр дүн сайнгүй буюу 1 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүний үндсэн шалтгаанууд бол зээлийн хэт өндөр шаардлага болон иргэдийн мэдлэг, олгох байгууллагуудын хүртээмж бага байгаагаас гэж үзэж байна. Мөн цаашид манай оронд “ Ногоон зээл ” нь хөгжих асар их боломжтой ба хүртээмжтэй байдлыг хэрхэн нэмэгдүүлэх талаар эрэлхийлсэн судалгаа шинжилгээ хэрэгтэй тул энэхүү судалгааны ажлаараа тэрхүү арга , замуудыг тодорхойлохыг зорилоо.

**Эдийн засгийн бүтээлийн сэтгүүлийн ангиллын индекс:**

**Түлхүүр үгс:** Ногоон зээл , банк бус санхүүгийн байгууллага , тогтвортой хөгжил, ногоон бичил санхүү , бичил санхүүгийн байгууллага

## **ОРШИЛ**

### **Судалгааны үндэслэл**

Хүн төрөлхтний нийгэм болон байгаль орчинд хийсэн буруу үйлдлээс болж цөлжилт, озоны давхрын цооролт, дэлхийн дулаарал, хойд туйлын мөс хайлах гэх мэт дэлхийн хэмжээнд нөлөө бүхий томоохон асуудлууд гарч ирсээр байна. Үүнийг шийдэх цаашид багасгах зорилгоор НҮБ-ээс “Тогтвортой хөгжил 2030 хөтөлбөр”-ийг 17 зорилго 169 зорилтыг тавьж хэрэгжүүлэхээр болсон билээ. Энэхүү хөтөлбөрт нийт 193 орны удирдагчид оролцон баталсан. Тогтвортой хөгжлийн хамгийн том тулгуур бол ногоон санхүүжилт билээ. Дэлхий дахинаа Ногоон санхүүжилт, ногоон зээл, ногоон бизнес эрчээ авч эхнээсээ үр дүнгээ өгч байна. Мөн манай оронд ч хэрэгжиж эхлээд багагүй хугацаа өнгөрсөн байна. Жишээ дурдвал Засгийн газрын 2018 оны 157 дугаар тогтоолын дагуу агаар цэвэршүүлэгч, эрчим хүчний хэмнэлттэй халаагч төхөөрөмжүүдийг гаалийн албан татвар болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсөн билээ. Гэсэн хэдий ч манайд ногоон бизнесийг дэмжих эх үүсвэр дутмаг байна.

Манай орны нийт зээлийн 1.2 хувийг эзэлж байна. Уг зээл нь байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж болон иргэнд хөнгөлөттэй хүүтэй, БОАЖЯ-наас тус зээлийн эх үүсвэрт зориулж гурван тэрбум төгрөгийн санхүүжилтийг Хас банканд 1.8 тэрбум, Хаан банканд 800 сая, Төрийн банканд 400 сая төгрөгийг 2019 оны 8-р сард төсвөөс олгон тус тус хуваан шилжүүлсэн. Гэсэн хэдий үр дүн сайнгүй буюу 1 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүний үндсэн шалтгаанууд бол зээлийн хэт өндөр шаардлага болон иргэдийн мэдлэг, эх үүсвэр олгох байгууллагуудын хүртээмж бага байгаагаас гэж дүгнэж байна. Мөн цаашид манай оронд “Ногоон зээл” нь хөгжих асар их боломжтой ба хүртээмжтэй байдлыг хэрхэн нэмэгдүүлэх талаар эрэлхийлсэн судалгаа шинжилгээ хэрэгтэй тул энэхүү судалгааны ажлаараа тэрхүү арга, замуудыг тодорхойлохыг зорилоо.

### **Судалгааны зорилго**

Энэхүү судалгааны ажлын зорилго нь Монгол улсад банк бус санхүүгийн байгууллагаар дамжуулан ногоон зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх арга замыг тодорхойлоход оршино.

### **Судалгааны ажлын зорилтууд**

- Ногоон зээл болон ББСБ-тай холбоотой онол арга зүйн судалгаа хийх
- Манай оронд болон бусад улс оронд хэрэгжиж буй ногоон төсөл болон санаачлаг, ногоон санхүүжилтийн өнөөгийн байдлын талаар судлах
- Бусад орнуудын банк бус санхүүгийн байгууллагын ногоон зээлийн туршлагатай танилцаж, хүртээмжтэй арга замыг тодорхойлох

### **Судалгааны арга зүй**

Онолын судалгаа, ногоон санхүүжилт болон Монголын ББСБ өнөөгийн байдлын судалгаа хийх ба тухайн байгууллагаас ярилцлага авах болон олон улсын байгууллагуудтай харьцуулан дүн шинжилгээ хийх замаар боловсруулна.

### **Судалгааны объект**

Уг судалгааны объектын хувьд банк бус санхүүгийн байгууллага, ББСБ-аас олгох ногоон зээл, түүний санхүүжилтийн эх үүсвэрийг авч үзнэ.

## I БҮЛЭГ. СЭДВИЙН СУДЛАГДСАН БАЙДЛЫН ТОЙМ

Энэхүү судалгааны ажлын хүрээнд ногоон бичил санхүүжилттэй холбоотой гадаадын болон дотоодын судалгааны ажлуудыг тоймлон авч үзлээ.

### 1.1 Гадаадад судлагдсан байдал

1. Why do microfinance institutions go green? (Allet, Why do microfinance institutions go green?, 2011)

Энэхүү судалгааны зорилго нь бичил санхүүгийн байгууллагууд яагаад ногоон санхүүжилтрүү шилжихээр болсон талаар дүн шилжилгээ хийх юм. Мөн ногоог бичил санхүүжилтийг эмпирик судалгааны аргыг ашиглан тодорхойлохыг зорьсон анхны судалгаа ба 23 бичил санхүүгийн байгууллага хамааруулсан байна. Тоон болон чанарын судалгаа нь дээр үндэслэгдсэн ба БСБ-ууд хуулийн дагуугаас гадна нийгмийн хариуцлагийн хүрээнд ногоон санхүүжилтрүү шилжсэн байна. БСБ нь бусад байгууллагатай харьцуулахад хөдөө орон нутгийн аж ахуйн нэгж болон иргэдтэй илүү хүртээлтэй бөгөөд байгаль орчинд илүү эерэг нөлөөлдөг гэж дүгнэжээ.

2. Measuring the environmental performance of microfinance: a new tool. Cost management (M. Allet, 2012)

Энэхүү судалгааны үндсэн зорилго нь анх 2011 онд БСБ-ын байгаль орчны үйл ажиллагааг хэрхэн хэмжих болон БСБ-ын санхүүгийн байдал, хэмжээ, үйл ажиллагаа явуулсан хугацаа нь байгаль орчны гүйцэтгэлд нөлөөлдөг эсэх талаар анх удаа Marion Allet эрдэмтэн дэлхийн 160 БСБ-ыг хамруулсан судалгаа хийсэн. Судалгаагаар 78 хувь нь байгаль орчин хамгаалах үүрэгтэй гэж үзжээ. Гэвч хамрагдсан БСБ-үүдийн дийлэнх нь энэхүү үүрэгт ямар арга барил болон стратеги баримтлахаа мэддэггүй байна. Энэхүү судалгаагаараа судлаач БСБ-ын байгаль орчны гүйцэтгэлийг хэмжих 5 шалгуур, 18 үзүүлэлт бүхий арга зүйг боловсруулсан байна.

3. Green Loan Principles to Guide Environmental and Sustainability finance (Hussain, 2018)

Энэхүү судалгаа нь Зээлийн холбоо болон Ази Номхон далайн зээлийн холбоо хамтран хийжээ. Судалгааны гол зорилго нь ногоон зээлийн зарчимын жишиг үзүүлэлтүүдийг батлах тухай юм. Тэд ногоон зээлийг хөгжиж буй зах зээл гэж үзэж байгаа бөгөөд байгаль орчин, тогтвортой хөгжлийн зорилготой уялдуулан зээл олгоход санхүүгийн байгууллагыг чиглүүлэх ногоон зээлийн сайн шалгуур нь энэхүү зах зээлийг хурдацтай өсөхөд түлхэц болно гэж дүгнэжээ. Уг журам, дүрмийг хангасан газруудад зээл олгож эхлэсэн ба тус журамын хамгийн онцлог заалт нь байгаль орчны хүлээгдэж буй үр дүнг тодорхой дүгнэсэн байх шаардлагатай гэж заажээ. Үүнд зээлдүүлэгч нь зээлдэгчээс хэрхэн зарцуулах, ногоон төслийн зорилго, ногоон зээлийн ангилалд тухайн төсөл багтаж байгаа эсэх, орлого зардагын ил тод байдал гэх мэт шаардлагуудыг тавьх хэрэгтэй гэсэн байна.

4. Green microfinance: A new frontier to inclusive financial services (Gonzalez, 2016)



Энэхүү судалгааны үндсэн зорилго нь ББСБ-аар дамжуулан, банкнаас зээл авч чадахгүй байгаа жижиг дунд аж ахуй нэгж болон хувь хүмүүст эдийн засгийн боломж олгох замаар байгаль орчны нөхцөл байдлыг сайжруулах боломжтой гэж үзжээ. Мөн ногоон санхүүжилт нь бусад санхүүжилтыг бодвол зээлдүүлэгч болон зээлдэгчээ илүү тогтвортой байлгахад гадна аж ахуй нэгж байгууллага иргэдийг байгаль орчноо хамгаалж, нөхөн сэргээх, бохирдлыг бууруулах, нөөц баялагийг хайрлаж, гамнахад эерэг нөлөө үзүүлдэг гэж дүгнэжээ.

## 5. The Impact of Green Lending on Credit Risk in China (Sean Geoboy, 2018)

Энэхүү судалгаа нь Хятад улсын ногоон зээлийн бодлогыг зээлийн эрсдэлийн үүднээс дүгнэжээ. Тус улсад ногоон зээлийн бодлого гарснаас хойш ногоон санхүүжилт болон ногоон бизнес хурдацтай тэлжээ. Уг судалгааны үндсэн зорилго нь ногоон зээл нь ногоон бус зээлээс эрсдэл багатай эсэхийг судлахыг зорьсон билээ. Судлаачид 24 Хятадын банкны сүүлийн 5 жилийн тайлан, мэдээлэл дээр тулгуурласан ба ногоон зээл нь чанаргүй зээлийн хэмжээг багасгадаг уу эсвэл үгүй юу талаар судалжээ. Нийт зээлийн хэмжээнд ногоон зээлийн хэмжээ их байх нь тус банкны зээлийн хүүг бууруулдаг ба санхүү болон байгальд эерэг нөлөөг зэрэг үзүүлдэг гэдэг үр дүнд хүрчээ.

### 1.2 Дотоодод судлагдсан байдал

#### 1. Монгол улсын ногоон зах зээлийн судалгаа (ЭМ ЭМ СИ ЖИ ХХК, 2016)

Энэхүү судалгааны үндсэн зорилго нь манай оронд шаардлагатай ногоон зээлийн нийт эрэлтийг судлах бөгөөд судалгааны арга зүй боловсруулсан байна. Арга зүйг тодорхойлохдоо шаардлагатай хүчин зүйлсүүдийг тодорхойлж, нөлөөллийг тооцсон ба үр дүнд нь ногоон зээлийг цар хүрээг тэлэх хэрэгтэй гэжээ. Мөн ногоон зээлийн шалгуурт голцлон технологийг авч үзэх нь оновчгүй гэсэн ба тооцооллын тогтолцоо шаардлагатай гэж дүгнэжээ.

#### 2. Иргэдийн ногоон зээлд тавигдах шалгууруудыг багасгах болон ногоон зээлийн талаарх иргэдийн мэдлэгийг тэлэх нь (В.Билгүүдэй, 2021)

Энэхүү судалгааны гол зорилго нь иргэдэд зориулсан ногоон зээлийг амжилттайгаар хөгжүүлж өргөжүүлэх, саад болох хүчин зүйлсийг илрүүлж засах, иргэдийн ногоон зээлийн мэдээллийг тэлэх юм. Энэхүү судлаач нь Монгол улсад ногоон зээлийн үйлчилгээг зайлшгүй явуулах нөхцөл нэн шаардлагатай байгаа бөгөөд хэрэгжилт удаан байгаагийн шалтгаан нь иргэдийн мэдлэг сургалт дутмаг байна. Мөн уул уурхайн салбар байгальд учруулах сөрөг нөлөө ихтэй тул нөхөн сэргээлтэнд чиглэсэн хөнгөлөлттэй зээл олгох хэрэгтэй байна.

#### 3. Арилжааны банкуудын тогтвортой санхүүжилттэй холбогдох үйл ажиллагааг нэмэгдүүлэх нь (Б.Азжаргал, 2019)

Энэхүү судалгааны ажил нь Монгол дахь банкуудын тогтвортой санхүүжилттэй холбоодох уялдаа, холбоог сайжруулах, тогтвортой эдийн засагт үзүүлэх оролцоог нэмэгдүүлэх, бодит үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилготой юм. Банкууд бүх шатны үйл ажиллагаандаа тогтвортой хөгжлийн зарчмуудыг авч үзэх хэрэгтэй. Мөн нийгмийн хариуцлага болон стратегийн шинэчлэлт зэрэгтээ анхаарал хандуулах хэрэгтэй гэсэн байна. Тогтвортой санхүүжилтийн зарчмуудыг хэрэгжүүлснээр чанаргүй зээлийн үзүүлэлт бууруулах боломжтой гэж үзжээ.

4. Арилжааны банкин дахь ногоон зээлийн эрсдэлд нөлөөлөгч хүчин зүйлсийн судалгаа (М.Энхжин, 2022)

Энэхүү судалгааны ажлын зорилго нь манай орон дахь арилжааны банкин дахь ногоон зээлийн эрсдэл, түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийг тодорхойлох, энэхүү зээлийн эрсдэлийг урьдчилан таамаглаж, хамгийн бага хэмжээнд барих боломжийг эрэлхийлэх юм. Үр дүнд нь банканд хамгийн эрсдэлгүй сонголт нь гуравдагч этгээдтэй хамтран ажиллах эсвэл гаднаас хямд өртөгтэй эх үүсвэр татах сонголт нь эрсдэл багатай ба энэ нь ашгийн төлөө гэхээс илүү байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа төсөл хэрэгжүүлэх зорилготой байна.

5. Монгол улсын хөгжлийн бодлогын тогтвортой байдал, залгамж чанар, уялдаанд хийсэн шинжилгээ (Т.Намжин, 2018)

Уг судалгаа нь олон улсад гарсан тогтвортой хөгжлийн баримт бичиг, тогтоолуудын холбоо уялдааг судалж, Монгол улс дахь тогтвортой хөгжлийн дунд үеийн бодлого, салбарын хөгжлийн бодлого, судалгааны арга зүйг тодорхойлоход зориулагдана. Энэхүү судалгаанд бусад орны туршлага болон санал зөвлөмжийг ямар нэгэн шүүлтүүргүйгээр хэрэгжүүлж байгаа нь манай оронд зохицохгүй байна гэж дүгнэжээ. Түүнчлэн урт хугацааны хөгжлийн бодлогод тохиромжгүй үйл ажиллагаа явуулах, сонгуульд ялсан нам өөрчлөлт оруулах нь буруу гэж үзсэн. Хөгжлийн бодлогыг үр дүнтэй, ашигтай байлгах оновчтой бодлого боловсруулах, дүгнэх, хэрэгжүүлэх судалгааны хүрээлэнг байгуулах хэрэгтэй гэж тодорхойлжээ.

### 1.3 Бүлгийн дүгнэлт

Энэхүү бүлгийн хүрээнд ББСБ-ын тогтвортой хөгжил болон ногоон санхүүжилттай холбоотой дотоодын болон гадаадын судлагдсан байдлын судалгаатай танилцаж өөрийн хэмжээнд товч дүгнэлт хийсэн ба тухайн сэдвийн гол санаа болон агууллагыг гаргаж ирэхийг хичээлээ.

## **II БҮЛЭГ. ОНОЛЫН СУДАЛГАА**

### **2.1 Банк бус санхүүгийн байгууллагийн тухай**

#### **2.1.1 Банк бус санхүүгийн байгууллага гэж юу вэ?**

Банк бус санхүүгийн байгууллага гэдэг нь өөрийн эзэмшигчийн хөрөнгөөр зээл олгох ба төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга, төлбөр тооцоо, валют арилжаа хийх үндсэн үйл ажиллагаа явуулдаг. Санхүүгийн зохицуулах хорооноос (СХЗ) зөвшөөрөл авсан ашгийн төлөөх бичил санхүүгийн байгууллага юм. Бичил санхүүгийн байгууллага нь бусад банк, санхүүгийн байгууллагаас илүү иргэд олон нийттэй түргэн шуурхай харьцаж байдгаараа давуу талтай байдаг. Гэхдээ дүрмийн сан нь СЗХ-оос тогтоосон хэмжээнд хүрсэн, ББС-ын үйл ажиллагаа амжилттай эрхлэх стратеги болон нөлөөлөх хүчин зүйлсийг оновчтой тусгасан бизнес төлөвлөгөөтэй, ББСБ-ын хуульд заасны дагуух удирдлагатай байх, аюулгүй ажиллагаа болон техник тоног төхөөрөмжийн зохих шаардлагатай түвшинд хангасан тохиолдол СЗХ нь ББСБ-ын тусгай зөвшөөрлийг олгодог байна. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичгүүд бол компани үүсгэн байгуулах баримт бичиг, бизнес төлөвлөгөө, дүрмийн сангийн хэмжээг нотлох баримт, санхүүгийн тайлан, боловсон хүчин ажлын байрны мэдээлэл, хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл, техник тоног төхөөрөмжийн талаарх мэдээлэл юм.

Бусад салбараас ялгарах онцлогууд нь өөрсдийн дүрмийн сантай, хадгаламж татдаггүй, цаашид арилжааны банк болох боломжтой, төрөлжсөн үйл ажиллагаа явуулж болдог. ББСБ нь дараах үйл ажиллагааг явуулна. Үүнд:

1. Зээл
2. Факторын үйлчилгээ
3. Төлбөх тооцооны хэрэгсэл гаргах
4. Төлбөрийн баталгаа гаргах
5. Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ
6. Гадаад валютын арилжаа
7. Итгэлцлийн үйлчилгээ
8. Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх
9. Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх
10. Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаануудыг өөрийн нэрийн доор явуулж болно.

ББСБ-ийн үйл ажиллагааг зохицуулдаг хуулиуд бол иргэний хууль, компанийн тухай хууль, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. Санхүүгийн зохицуулах хорооноос ББСБ-д хяналт тавьж, шалгалт хийдэг ба зөвшөөрлийн дагуу үйл ажиллагааг удирдан чиглүүлэх этгээд нь Монгол улсын болон гадаад улсын хуулийн этгээд эрхлэж болно.

ББСБ эрхлэхэд хэд хэдэн үйл ажиллагаанд тавигдах шаардлага байдаг ба үүнээс дурдвал нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгох зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийт дүн тухайн ББСБ-ын өөрийн

хөрөнгийн 30 хувиас хэтэрч болохгүй . Мөн гарах төлбөрийн баталгааны нийт дүн нь өөрийн хөрөнгийн 70 хувиас илүүгүй байна.

### **ББСБ-ын үүсэл хөгжил**

Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ) нь хөгжингүй орнуудад XVII зууны үеэс бий болсон гэж судлаачид үздэг. Анхны хэлбэр нь хадгаламж зээлийн хоршоо ба баруун европын улс гүрнүүдэд үүссэн гэдэг. Жишээлбэл 1789 онд Францад хөрөнгөтний хувьсгал ялж, феодалын харилцааг буулгаснаар хөрөнгөтний шинэ капитализм тогтсон үед Францын хэсэг ажилчид үйлдвэрлэлийн бичил хоршоог бие даан үүсгэжээ. 16-р зуунд Англид болсон аж үйлдвэрийн хувьсгал нь хөдөлмөрчин хүмүүсийг амьдрал аж ахуйг нь доройтуулж , өргөн хэрэглээний бараа болон хүнсний бүтээгдэхүүнүүдийн хомсдолд оруулжээ. Хөдөө аж ахуйг хөгжүүлэх, дэмжих бодлогыг авч хэлэлцээгүйгээс улбаалан хөдөө аж ахуйн эрхлэгчидийн санхүүгийн чадвар буурсан байна. Энэ үед буюу 1840-өөд оны үед Манчестр хотын хөдөө аж ахуй эрхлэгчид сайн дураараа нэгдэн анхныхаа хоршоог байгуулж түүгээрээ дамжуулан өөрсдийн амьдралын хэрэгцээгээ хангах болсон. Энэхүү туршлага нь хэрэглэгчдийн хоршоо нэрийн доор баруун Европ болон дэлхийн бусад оронд дэлгэрчээ. Хоршооллын хөгжилд хамгийн их хувь нэмэр оруулсан нь 1844 онд Англи болон Ромд байгуулагдсан Рочдейлийн нийгэмлэг гэж судлаачид үздэг байна.

Монгол улсад анх 1998 онд “Хөгжлийн алтан сан” гэх бага, дунд орлоготой иргэдэд чиглэсэн зээл болон бичил санхүүгийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор үйл ажиллагаагаа улс орныхоо иргэдэд зориулан эхлүүлжээ. 2002 онд ББСБ үйл ажиллагааны тухай хуулийг УИХ санаачлан баталсан ба олон ББСБ-ууд байгуулагдах үндэс суурь болон хөгжиж иржээ.

## **2.2 Зээлийн тухай**


### **2.2.1 Зээлийн гэж юу вэ?**

Зээл гэдэг нь зээлдэгч тодорхой хэмжээний мөнгөн хөрөнгийг тогтсон хугацааны дараа хүүний хамт зээлдүүлэгчид эргүүлэн төлөхөөр тусгасан хоёр талын гэрээ хэлцэл юм. Зээл нь ААН, иргэдийн бизнесийн үйл ажиллагаанд шаардагдах эргэлтийн болон хөрөнгө оруулалтын санхүүжилтэд зориулан тодорхой төсөл төлөвлөгөө, эргэн төлөгдөх хугацаа, зориулалттай, зохих хүүтэйгээр олгох хөрөнгө юм. Өөрөөр хэлбэл эдийн засгийн тодорхой субъектэд чөлөөлөгдсөн мөнгөн хөрөнгө, нэмэгдэл хөрөнгө мөнгийг түр зуурын хэрэгцээ шаардагдсан өөр субъектэд шилжи байгаа өртгийн харилцааны онцгой хэлбэр юм.

Банк тодорхой зориулалт, хугацаа, хүү, эргэн төлөгдөх барьцаа эсвэл батлан даалттайгаар өөрийн болон өөрт хадгалуулсан бусдын мөнгөн хөрөнгийг зохих хэсгийг өөрийн нэрийн өмнөөс өөр бусад этгээдэд олгохыг хэлнэ.

Банкны зээлийг дараах байдлаар ангилна.

Зураг 1 Зээлийн ангилал



эх сурвалж: (Л.Оюун, 2004)

Банкны зээлийг зориулалт, хугацаа, барьцаа, чанараар нь авч үздэг.

- Банкны зээлийн зориулалтаар нь :
  - Иргэдийн зээл
  - Үл хөдлөх хөрөнгийн зээл
  - Арилжааны зээл
  - Үйлдвэрлэлийн зээл
  - Хөдөө аж ахуйн зээл
  - Орон нутаг засаг захиргааны зээл
  - Олон улсын зээл гэж ангилна.
- Зээлийн барьцаагаар нь :
  - Барьцаатай зээл. Энэ нь зээл авахын тулд барьцаа болгож зээлдэгч нь өөрийн нэр дээрх хөрөнгөө тавьж буйг хэлэх ба биет болон баталгаат гэж 2 ангилдаг.
  - Барьцаагүй зээл. Энэхүү зээлийн онцлог нь зээлдэгчийн нэр хүнд, байнгын найдвартай харилцаа, ирээдүйн орлого, өрийн бичиг зэргийг харгалзан үзэж барьцаагүй олгодог юм.
- Зээлийн чанараар нь :
  - Хэвийн зээл. Тогтмол төлөлтөө хугацаандаа төлж байгаа буюу төлөгдөж дуусах хугацаа нь болоогүй зээлийг хэлнэ.
  - Хугацаа хэтэрсэн зээл. Тогтсон төлөх ёстой хугацаанаас 91 хоног хүртэлх хугацаа хэтэрсэн зээлийг хэлнэ.
  - Хэвийн бус зээл. Тогтсон төлөх ёстой хугацаанаас 91-181 хоногоор хугацаа хэтэрсэн зээлийг хэлнэ.
  - Эргэлзээтэй зээл. Тогтсон төлөх ёстой хугацаанаас 181-270 хоногоор хугацаа хэтэрсэн зээлийг хэлнэ.
  - Найдваргүй зээл. Тогтсон төлөх ёстой хугацаанаас 360 хоногоор хугацаа хэтэрсэн зээл, зээлдэгч нас барсан, барьцаа хөрөнгө байхгүй болсон, төлбөр төлөх чадваргүй болсон болон дампуурсан нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон зээлийг хэлнэ.

- Чанаргүй зээл. Барьцаа хөрөнгийн зах зээлийн үнэ буурсан, үйл ажиллагаа болон борлуулалтын орлого саатсан гэх мэт шалтгаанаас үүдэн тогтмол төлөлтөө гэрээнд заасан хугацаандаа төлөөгүй зээлийг хэлнэ.

### **Ногоон санхүүжилт ба тогтвортой санхүү**

Тогтвортой санхүү нь аливаа санхүүгийн шийдвэр гаргалтанд нийгэм байгаль орчин болон засаглалын шалгуур үзүүлэлтүүдийг нэгтгэх тухай ойлголт юм. Тухайлбал тогтвортой санхүү гэж ногоон санхүү, уур амьсгал, байгаль орчинд ээлтэй болон нөөц хэмнэсэн хэрэглээнээс эхсүүлээд нийгэм байгаль орчинд ээлтэй хөрөнгө оруулалтын төслүүдийн санхүүжилтийг хэлдэг. Мөн нийгмийн сайн сайхан болон байгууллагын засаглал, менежментийн хүчин зүйлсийг тооцдоогоороо илүү өргөн хүрээтэй байдаг. Энэхүү санхүүжилтаар санхүүжих төслүүд нь зөвхөн хувь нийлүүлэгчиддээ ашигтай байгаад зогсохгүй нийгэм, эдийн засаг, байгаль орчины сайн сайхан байдалд эерэгээр нөлөөлж, хор хохирол учруулах ёсгүй байдаг. Тодруулбал хууль журмыг сахидаг байх, татвараа төлсөн байх, засаглал ёс суртахуунтай байх, иргэдийн амар тайван байдал, эрх ашгийг хөндөөгүй байх, хог хаягдалаа зөв ангилан хаягддаг байх, түүх соёл иргэншлийн зүйлсэд аюул хохирол учруулаагүй байх гэх мэтчилэн хүн болон нийгмийн сайн сайхан байдлыг давхар тооцооллоно гэсэн үг юм. Хүн, нийгмийн хүсэл, асуудлууд хязгааргүй тул олон талаас нь бодолцон үзэж, тогтвортой санхүүгийн хүрээ, шалгуурууд олон төрөл янз байх хэрэгтэй.

Ногоон санхүүжилт нь тогтвортой санхүүгийн чухал хэсэг ба үүнд бохирдлыг бууруулах, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, нөөц баялагийг хэмнэх, байгаль орчинд ээлтэй амьдралын хэв маяг, бизнесүүдийг дэмжих боловч хувь нийлүүлэгч нарт ашигтай байх талаас нь тооцоолсон төсөл, санхүүгийн хэрэгслүүд багтана. Ногоон санхүү нь уур амьсгалын санхүүг өөртөө багтаах ба хамрах хүрээ өргөн, хөрөнгө оруулагчид, бодлого боловсруулагчид, төрийн бус байгууллагууд, байгаль орчны мэргэжилтэнүүд гээд олон оролцогч нартай, ярвигтай тул ногоон санхүү гэснээс өөр нэгдсэн нэг ойлголт хараахан бий болоогүй байна.

“Тогтвортой хөгжлийн зорилго” (ТХЗ) анх 2012 онд Бразилийн Рио-де-Жанейро хотод болсон Нэгдсэн үндсэн байгууллагын (НҮБ) чуулганы үеэр анхны санаачлага нь гарсан ба 2014 оны 7 сарын 19-ны өдөр НҮБ-ын ерөнхий Ассамблей нь чуулганд дэлхийн тогтвортой хөгжлийн 169 асуудлыг хөндсөн 17 зорилт бүхий удирдамжийг танилцуулсан. 2016 оны 1 сарын 1-нээс ТХЗ-г албан ёсоор нийтээр хэрэгжиж эхлэсэн. Энэхүү зорилгууд нь дэлхийн ядуурал болон өлсгөлөнг зогсоох, боловсрол болон эрүүл мэндийг дээшлүүлэх, улс орон хотуудын тогтвортой байдлыг хангах, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх, ой далай тэнгисийг хамгаалах гэх мэт дэлхийд нийтээр тохиолдож буй олон асуудлыг хөндсөн байдаг. 2015 оны 9 сарын 25-27ны өдрүүдэд АНУ-ын Нью-Йорк хотноо болсон НҮБ-ын дээд хэмжээний уулзалтанд “Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөр”-ийг 193 орны удирдагчид баталжээ.

“Тогтвортой хөгжил 2030 хөтөлбөр”-ийн хүрээнд доорх 17 зорилго 169 зорилт тавьжээ.

Зураг 2 Тогтвортой хөгжлийн зорилгууд



Эх сурвалж: (United Nations Development Program, 2015)

НҮБ-ээс энэхүү зорилгуудыг улс орнуудад өөрсдийн онцлогтоо тулгуурлан, өөрийн оронд тохирсноо хэрэгжүүлээрэй гэж зөвлөсөн байдаг. Мөн энэ зорилгуудад хамгийн их уялдан холбогдох сэдэв нь ногоон хөгжил билээ. Ногоон хөгжлийн хэд хэдэн ойлголт байдаг. Үүнд:

- **Ногоон хөгжил** нь байгалийн нөөцийг үр ашигтай, хэмнэлттэй ашигласан, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, экосистемийг тэтгэсэн, нийгмийн оролцоог ханган ядуурлын бууруулах хөгжлийн загвар;
- **Ногоон эдийн засаг** нь байгаль орчны эрсдэл, нийгмийн тэгш хүртээмжтэй байдал, доройтлыг багасгахын зэрэгцээ хүний сайн сайхан байдлыг сайжруулах зорилго бүхий эдийн засгийг
- **Ногоон өсөлт** нь хүрээлэн байгаа орчны тогтвортой байдлыг хадгалах, хүлэмжийн хийн ялгарал багатай эдийн засгийн өсөлт, нийгмийн оролцоог
- **Ногоон үйлдвэрлэл** нь нөөцийн хэмнэлттэй, эрчим хүч, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, хүрээлэн байгаа орчин болон хүний эрүүл мэндэд эрсдэлгүй үйлдвэрлэлийн үйл ажиллагааг,
- **Ногоон ажил** нь түүхий эд материал, эрчим хүч, хүлэмжийн хийн ялгарлыг хязгаарлах, хог хаягдал, бохирдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлд зохицох журмаар хүрээлэн байгаа орчны чанарыг сайжруулж, хамгаалахад чиглэсэн ажил хөдөлмөр, экосистемийг хамгаалж нөхөн сэргээхийг

- **Ногоон хот** нь харилцаа холбоо нийгмийн ухаалаг дэд бүтэц , эрчим хүч, дулаан ус хангамж, хог хаягдлын оновчтой менежмент бүхий хүний амьдралын тав тух, хөгжлийн боломжийг хангасан хот сууринг
- **Ногоон барилга** нь дулааны алдагдлыг хамгийн бага байлгах хийцтэй, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөгүй материал ашигласан, агаарт ялгаруулах хаягдал багатай халаалтын шийдэлтэй, нөөцийн хэмнэлт үр ашигтай, хур тунадасны усыг хуримтлуулж ашиглах, эрчим хүч нөөцийн хэмнэлттэй мөн үр ашигтай, хаягдал бохир усаа цэвэрлэж зайлуулах технологи бүхий, тав тухтай орчныг бүрдүүлсэн барилга байгууламжийг
- **Ногоон худалдан авалт** нь байгалийн нөөц баялаг эрчим хүчний хэмнэлттэй хэрэглээ, экосистемийн үйлчилгээний тогтвортой байдлыг хангах, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох бараа, ажил, үйлчилгээг
- **Ногоон санхүүжилт** нь байгалийн нөөц баялаг болон экосистемийн үнэ цэнийг хадгалж, түүхий эд материал, усны хэрэглээг багасгах технологи ашиглах төсөл, үйл ажиллагааг санхүүжүүлэх, тэдгээрт хөрөнгө оруулахыг
- **Ногоон татвар** нь байгаль орчинд сөрөг нөлөөтэй үйл ажиллагаа, үйлчилгээ, үйлдвэрлэл, бараа бүтээгдэхүүний импорт, хэрэглээг багасгахад чиглэсэн татварыг
- **Экосистемийн үйлчилгээ** нь байгалиас заяасан түүхий эд, хүнс, нөөцөөр хангах орчин болон уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг зохицуулах, хүний амьдралыг тэтгэж, оюуныг сэргээх үр өгөөжийг
- **Экосистемийн үйлчилгээний төлбөр** нь экосистемийн үйлчилгээг хүртэгч болон уг үйлчилгээг тогтвортой хангаж хадгалахад хувь нэмрээ оруулдаг хүмүүсийн хооронд бий болох төлбөрийн зохицуулалтын механизмыг
- **Ногоон таксономи** нь байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт, тодорхойлолт, ангилал ба хөрөнгө оруулагчид, санхүү, банкны байгууллагууд, бодлого боловсруулагчид энэхүү таксономийг ногоон хөрөнгө оруулалттай хөтөлбөр, төсөл болон ногоон зээлийг тодорхойлохдоо ашиглана. Мөн ямар нэгэн салбараар хязгаарлагдалгүй бүх салбаруудыг хамааруулж чадах шалгуур үзүүлэлт юм.

### 2.2.2 Ногоон зээл

Ногоон зээл гэж “ногоон төсөл”-ийг санхүүжүүлэхэд чиглэсэн төслүүдийг санхүүжүүлэх эсвэл бизнес эрхлэгчдэд байгаль орчин нийгмийн хувьд тодорхой нөлөө үзүүлэх боломжийн олгох, чадавхижуулах зорилготой санхүүжилтийн хэлбэр юм. Хамгийн гол үзэл баримтлал нь ногоон зээлийг бүтэцжүүлэх, сонгох, ашиглах, тайлагнах бүх үйл явцын туршид ногоон чиг бүхий аргачлалыг багтаасан гэдгээрээ илүү өргөн агуулгатай. Ногоон зээл нь 2018 оны “Ногоон зээлийн зарчим”-ын дагуу заасан шалгуур үзүүлэлтээр тодорхойлдог. Зээлийн зах зээлийн олон улсын холбоо нь 2020 оны 5-р сард гаргасан удирдамж болгон “Ногоон зээлийн зарчим” (Green loan Principles - GLP) гэх стандарт, удирдамжийг өндөр түвшинг бий болгосон ба зах зээл дээр хэрэгдэгдэх ногоон зээлийн зохистой арга зүйг бий болгосон. GLP нь гүйлгээний шинж чанараас хамааруулан зах зээл дээр харилцан тохиролцож ашиглагдах зааварчилгаа юм.



## Ногоон зээлийн зарчмууд

### 1. Орлогын ашиглалт

Ногоог зээлийн дотоод бүрэлдэхүүн хэсэг нь сангууд юм. Гэхдээ зөвхөн ногоон төсөл санхүүжүүлэх эсвэл ахин санхүүжих үорилгоор хийсэн зүйл юм. Ногоон зээлийн зарчим нь төслийн шаардлагад нийцсэн төсөл хөтөлбөрүүдийн жагсаалтыг гаргасан бөгөөл нийтлэг төслийн зорилго шинж байдал нь тодорхой, харьцуулан ялгаж болохоор орчны нөлөөлөл болон ашиг тусаа өгөх хэмжээний байх ба бодит байдал дээр хэрэгжих боломжтой мөн хооронд нь ялгаж болох, хэмжигддэг байх хэрэгтэй. Мөн уур амьсгалын эрс тэс өөрчлөлт, байгалын баялагын хомсдол, биологийн тэнцвэрт байдал алдагдах, болон хүний гараар бий болсон бохирдолтой тэмцэх зэрэг асуудлууд руу хандаж шийдэл гаргаж ирсэн төслүүд байна. Хамгийн хачирхалтай нь ногоон зээлийн зарчимийн удирдамжийн хурлын тэмцдэглэлд ногоон зээлийн санхүүжилт нь тухайн зээлийн зээлдэгч дан ганцаараа авч болохгүй ба байгалын ашигт малтмалын үр ашгийг мэдэгдэхүйц хэмжээнд үр агшийг нэмэгдүүлэх төслүүд багтдаг ба үүнээс бусад шалгуураа бүгдийн хангасан тохиолдолдзээл чадах боломжтой болох юм.

### 2. Ногоон зээлийн төслийн үнэлгээ болон сонголт

Төслийн шалгаруулалтад ил тод байх, шулуун шударга байх үүднээс ногоон зээлийн зарчим (GLP) бол ногоон зээлийн санхүүжилт авахаар шийдсэн бол ирээдүйд ямар нэг зээлдэгчээр дамжуулан танилцуулхаар шийдэж байгаа ногоон зээлийн төслийн хамгийн чухал зүйлийг тодорхойлсон байдаг. Ирээдүйд ямар нэгэн зээлдэгчийн төсөлд байгал орчны тогтвортой байдлын зорилт болон тухайн төсөл энэхүү зээлийн шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг мэдэгдэж байх хэрэгтэй. Үнэлгээ нь ногоон төсөлтэй холбоотой ирээдүйд зээлдэгчид тулгарах эрсдэлийг тэнцвэржүүлэх, байгаль орчны болзошгүй материаллаг эрсдлийг тодруулахыг шинжилсэн ногоон стандарт болон гэрчилгээг харуулсан байдаг.

### 3. Орлогын ашиглалтын удирдлага болон хяналт

Зээлдэгчид орлогын бодит хэрэглээг хэрхэн удирдахад чиглэгддийг GPL-ийн гуравдахь бүрэлдэхүүн хэсэг гэнэ. GPL-үүд зөвлөхдөө ногоон зээлийн орлого нь зээлдэгчийг гадагш чиглэсэн урсгалыг дагаж мөрдөх боломж олгох, бүрэн бүтэн байдлыг дэмжих зорилгоор тусгай зээлийн дансанд төвлөрүүлэхийг зөвлөдөг. Хөндлийн хяналт шаардагдах эсэхээ урьдчилан тохирсон байх нь зээлдүүлэгч болон зээлдэгч зээлийн ашиглалтын хугацааны туршид гүйцэтгэлийг үнэлэх зориулалттай юм. Туршлагаас дүгнэхэд зээлдэгч дотоддоо хангалттай чадвар мэдлэгтэй эсвэл зээлдүүлэгчид зээлдэгч ба түүний үйл ажиллагааны талаар өргөн мэдлэгтэй бол өөрийгөө гэрчилгээжүүлэх нь тохиромжтой гэж дүгнэдэг.

### 4. Тайлан гаргах

Зээлдэгчээс GPL нь жил бүр орлогын ногоон төслүүдэд бодитоор хувиарласан байдал, орлогын ашиглалт, мөн байгаль орчин нийгэмд үзүүлэх нөлөөллийн талаар тайлагнаж, зөвлөж, ил тод байлгахыг уриалдаг. Чанарын болон тоон шалгуур үзүүлэлтүүдийн хэмжүүрүүдийг (жишээлбэл цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл, эрчим хүчний хүчин чадал, хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах эсвэл зайлсхийх гэх мэт) холимог болон үндсэн суурь арга зүй эсвэл таамаглалд үндэслэхийг GPL зөвлөдөг.

Ер нь GPL нь ногоон зээлийг удирдах, тодорхойлох, сонгоход чиглэсэн таксономийг тодорхойлдог ба ногоон эргэлтийн байгууламж, ногоон синдикат зээл, ногоон хангамжийн сүлжээний санхүүжилт, ногоон активын санхүүжилт зэрэг зээлийн олон төрөлт хэрэгслүүдэд хамааруулдаг.

Ногоон зээлийн үндсэн гол шинж чанар, тэмдэгүүдийг шинжилж, судлаад тэдгээрийн санхүүжүүлэгч болон бизнес эрхдэгчидэд анхаарал хандуулахуйц буй зүйлсийг сайн үнэлэхэд илүү анхаарах болжээ. Компанийн засаглалын болон нэр хүнд талаас судалж үзвэл ногоон зээл нь гало эффэкттэй байх ба зээлдүүлэгч болон зээлдэгчид тогтвортой эдийн засгийг дэмжиж, хөгжүүлэх хүсэлтэй байгаагаар бодитоор биелүүлэх боломжийг олгодог байна. Энэ нь давуу тал нь болж хувь нийлүүлэгчдийн хүлээлт, ач холбогдлыг улам бүр нэмэгдүүлдэг. Ногоон зээл нь зээлдэгчдэд илүү олон, өргөн сонголттойгоор хөрөнгө оруулалтын сан, тэр тусмаа нийгэм, байгаль орчин, засаглалын шалгуур бүхий эерэг нөлөөлөл, хандлагатай хөрөнгө оруулалт эрэлхийлж буй хувь нийлүүлэгчдийг олох боломжийг олгодог. (mondaq.com, 2020)

Ногоон зээл нь бусад зээлийг бодвол илүү эрсдэл дагуулж, өөрийн гэсэн хүндрэл, хязгаарлалт, бэрхшээлтэй байдаг. Үүнээс гадна, үзүүлэлтүүд нь санхүү болон тоон шинжтэй биш, байгаль орчин болон нийгэмд нөлөөлж буй эерэг болон сөрөг байхаас үл хамааран хэмждэг тул илүү хэцүү байдаг. Гэхдээ энэхүү хүндрэлүүдийг үл хамааран ногоон зээлийн олголтын зарчмуудыг тасралтгүй хөгжүүлж, хэрэгжүүлснээр засагдаж, илү сайжрах болно. Нийгэм байгаль орчны тогтвортой байдал хангагдаж ирснээр түүнийг хүрээлэн буй үйл ажиллагааны ашигт байдал нэмэгдэх магадлал өндөр юм. Ихэнх улс орны эдийн засаг ногоон төлөврүү шилжиж байгаа ба энэхүү үйлд ногоон зээл гол нөлөө үзүүлэгч юм. Ногоон зээлийг дэлгэрүүлснээр хүрээлэн буй орчинд эерэг нөлөө үзүүлэх зорилготой компаниуд ихсэж, нийгэм эзлэх байр сууриа томсгох боломжтой. Энэ нь хөрөнгө оруулагчдыг илүү ногоон болгож, олон нийтийн дэмжлэгийг ч хүртэх болно. Ногоон зээл нь улс орны эдийн засгийг нийгэм байгаль орчинд ямар нэгэн сөрөг нөлөөгүйгээр, ирээдүйг илүү дээшлүүлэх, сайхан амьдрах боломжийг багасгахгүйгээр хөгжиж, дэвших нөхцөлийг бүрдүүлдэг.

### 2.2.3 Ногоон бонд

Ногоон бонд гэдэг нь аливаа нэг албан байгууллагаас гаргасан хүрээлэн буй орчин, уур амьсгалд эерэг хувь нэмэртэй төслийн санхүүжүүлэх эсвэл дахин санхүүжүүлэх зорилготой өрийн үнэт цаас юм. Мөн хөрөнгө оруулагчдыг татахын тулд татварын хөнгөлөлт үзүүлдэгээрээ давуу талтай. Ногоон бонд нь үндсэндээ энгийн бондтой ижил бөгөөд хөрөнгө оруулагч нь тодорхой хугацааны эцэст анх оруулсан хөрөнгө оруулалтаа, хугацааны туршид хуримтлагдсан тогтмол хүүний төлбөрийг хүлээн авах нөхцөлтэй өрийн үнэт цаас юм. Ногоон бонд нь энгийн бондоос ялгарах гол онцлог нь санхүүжилтийг хүлээн авах төсөлдөө байдаг. Ногоон бонд нь зөвхөн байгаль орчинд эерэг хувь нэмэр оруулах төслийг санхүүжүүлдэг. (Team, 2022)


Ногоон бонд нь ихэвчлэн доорх төслүүдийг санхүүжүүлдэг:

- Сэргээгдэх эрчим хүчний төслүүд
- Эрчим хүчний хэмнэлтийн төслүүд

- Бохирдлоос урьдчилан сэргийлэх, хянах төслүүд
- Байгалийн баялаг, газар зохион байгуулалтын төслүүд
- Байгальд ээлтэй автотээврийн төслүүд /экомашин.../
- Бохир усыг дахин боловсруулах төслүүд
- Ногоон барилга байгууламжын төслүүд

Ногоон бондын үүсэл хөгжил нь 2007 онд НҮБ анх дэлхийн дулаарал болон хүний байгальд нөлөөлөх үйл ажиллагааны хамаарлыг илтгэсэн тайлан тавьсан. Энэ нь Шведийн тэтгэврийн сангуудыг байгаль орчинд чиглэсэн төслүүдийг санхүүжүүлэх талаар сэдэлжүүлжээ. Ногоон бондны эрэлт нэмэгдсэн тул 2008 онд Дэлхийн банк анх удаа “Ногоон бонд”-ыг гаргасан байна. Анхны ногоон бонд гарснаас хойших үзүүлэлтийг доорх 2 хүснэгтээр харуулав.

Зураг 3 Ногоон болон энгийн бондны өсөлтийн тоо хэмжээ



Эх сурвалж: (International Finance Corporation, 2020)

Зураг 4 Ногоон бондны зах зээлийн хэмжээ



Эх сурвалж : (International Finance Corporation, 2020)

Одоогийн байдлаар дэлхийн 50 гаруй орон ногоон бондыг зах зээлд нэвтрүүлсэн бөгөөд АНУ ногоон бондны хамгийн том эх үүсвэр болж байна.

### Ногоон бондын давуу тал

Ногоон бондын нэр хүнд өсөх нь үндсэндээ хөрөнгө оруулагчид нийгмийн хариуцлагатай хөрөнгө оруулалтыг хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд ердийн бондноос

илүү ашиг болон эрсдэлгүй ижил зарчмаар ажилладаг. Харин ногоон бонд нь татвараас чөлөөлөх, татварын хөнгөлөлт үзүүлэх зэрэг татварын таатай нөхцөлийг бүрдүүлдэг. Энэ хөрөнгө оруулагчдыг ногоон бондод хөрөнгө оруулахыг сонгох хамгийн том шалтгаан юм. Хууль ёсны баталгаажуулалт нь хөрөнгө оруулагчдад илүү итгэх байдлыг төрүүлж баталгаажуулж байдаг.

### **2.3 БҮЛГИЙН ДҮГНЭЛТ**

Судалгааны ажлын онолын хүрээнд ББСБ болон зээл, ногоон санхүүжилт, ногоон зээлийн талаарх онол ухагдахуунуудыг судлан авч үзлээ.

Банк бус санхүүгийн байгууллага нь бичил санхүүгийн байгууллагат харьяалагддаг ба банкыг бодвол бүх түвшиний харилцагчтай хурдан харьцдагараа давуу талтай юм. Тийм ч учраас илүү хурдан ногоон зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай тул ББСБ-ийн ногоон зээлийн бүтээгдэхүүнд анхаарлаа хандуулах шаардлага бий болоод байна.

Дэлхий дахинаа тулгамдаад буй томоохон асуудлын нэг нь хүрээлэн буй орчны эрүүл байдал юм. Энэхүү асуудлыг тэнцвэржүүлэх гол арга нь тогтвортой хөгжлийн зорилго, зорилт юм. Ногоон зээлийн хамрах хүрээ, хүртээлтэй байдал, чанар болон хэрэглээ зэрэг нь аль түвшинд байх нь хүрээлэн буй орчин болон эдийн засаг ямар байхтай шууд хамааралтай юм. Ногоон зээлийг ББСБ-тэй хослуулан хүртээмжийг нэмснээр бичил бизнес эрхлэгчдэд нэг томоохон боломжийг нээж өгөх арга зам гэж үзэж байна.

### III БҮЛЭГ. ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Энэхүү хэсэгт банк бус санхээгийн байгууллага болон ногоон зээлийн өнөөгийн байдал, зах зээлийн судалгааг хамааруулан авч үзнэ.

#### 3.1 Банк бус санхүүгийн байгууллагийн өнөөгийн байдал

##### ББСБ-ын тоо болон харилцагчдын тоон мэдээлэл

2022 оны 3-р улирлын байдлаар СЗХ-оос ББС-ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 522 ББСБ байгаа бөгөөд 2021 оноос 1.7 хувиар буурсан байна. Нийт тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудын 91 нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлдэг, 26 нь гадаадын хөрөнгө оруулалттай үйл ажиллагаа эрхэлж, 5 ББСБ нь олон нийтэд хувьцаагаа санал болгосон байна.

Хүснэгт 1 ББСБ-ын тоон мэдээлэл

Үзүүлэлтүүд	2018	2019	2020	2021	2022
Шинээр олгосон	13	9	12	9	14
Хүчингүй	7	9	8	10	26
Түдгэлзүүлсэн	17	10	25	20	57
Сэргээсэн	7	8	4	6	19
<b>Нийт ББСБ</b>	<b>540</b>	<b>539</b>	<b>533</b>	<b>531</b>	<b>522</b>
Үүнээс: ХОН	76	74	77	80	91
Үүнээс: ГХО	28	28	29	29	26
Салбар	206	240	285	313	419
Төлөөлөгч	5	7	9	8	7

Эх сурвалж: (СЗХ, 2022)

2022 оны 3-р улирлын байдлаар 14 ББСБ-д шинээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон ба 26 ББСБ-ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хэргэсэхгүй болгожээ. 19 ББСБ-ын үйл ажиллагаа болон зөвшөөрөлийг сэргээсэн бол 57 ББСБ-г түдгэлзүүлжээ. Мөн 36 ББСБ онлайн зээлийн үйлчилгээ үзүүлж байна. Онлайн зээлийн үйлчилгээг 36 ББСБ үзүүлж байна.

##### ББСБ-ын үйл ажиллагааны нэр төрөл

ББСБ-ын үйл ажиллагааны төрлөөр ангилвал 522 ББСБ 10 төрлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхэлдэг. Эдгээрээс 93 хувь нь буюу 492 ББСБ зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа ба үүнээс 60.7 хувь нь буюу 321 ББСБ дагнан эрхэлж байна. Мөн гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхэлж байгаа 144 ББСБ байгаа нь нийт ББСБ-уудын 27.3 хувийг, гадаад валютын арилжааны үйл ажиллагаа дагнан эрхэлдэг 37 ББСБ нийт ББСБ-уудын 7 хувийг бүрдүүлж байна.

## Хүснэгт 2 ББСБ-ын үйл ажиллагааны төрлүүд

№	Үйл ажиллагааны нэр төрөл	ББСБ-ын тоо		Өөрчлөлт	
		2021-III	2022-III	тоо	хувь
Нийт ББСБ-ын тоо		531	522	-9	-1.7%
1	Зээл	493	484	-9	-1.8%
<i>Зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг</i>		324	316	-8	-2.5%
2	Факторинг	38	43	5	13.2%
3	Төлбөрийн баталгаа гаргах	22	28	6	27.3%
4	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	5	5	-	0.0%
5	Цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулга	35	37	2	5.7%
6	Гадаад валютын арилжаа	147	140	-7	-4.8%
<i>Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг</i>		38	38	-	-
7	Итгэлцэл	46	61	15	32.6%
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	18	22	4	22.2%
9	Хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх	39	40	1	2.6%
10	Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	-	1	1	-

Эх сурвалж: (СЗХ, 2022)

Зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг ББСБ -ын тоо 2021 оны 3 дугаар улиралтай харьцуулахад 2.5-иар буурч, бусад төрлийн үйл ажиллагааны тоо нэмэгдэж байгаа нь ББСБ -ууд үйл ажиллагааны цар хүрээгээ тэлж байгааг харуулж байна. Харин өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн үйл ажиллагааны төрлийг авч үзвэл богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйлчилгээ 22.2 хувиар, итгэлцлийн үйлчилгээ 32.6 хувиар тус тус өссөн байна. Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгож буйгаас гадна уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн болгож буй цахим зээлийн үйлчилгээг 2022 оны 3 дугаар улирлын байдлаар 32 ББСБ үзүүлж байна. Мөн өмнөх оны мөн үел “Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа” -нд 1 үйлчилгээ үзүүлсэн байна. Нийт харилцагчидын тоо өмнөх оны мөн үеэс 5.2 хувиар өссөж, 1,6 сая болсон байна.

### ББСБ-ийн Санхүүгийн байдлын судалгаа

2022 оны 3 дугаар улирлын байдлаар ББСБ салбарын нийт хөрөнгө 3.4 их наяд төгрөгт хүрсэн нь 2021 оны 3 дугаар улиралтай харицуулахад 940.7 тэрбум төгрөг буюу 38.2 хувиар өсөлт үзүүлжээ. Цэвэр зээлийн өсөлт нь нийт активын өсөлтийн 93 %-ийг бүрдүүлж байна.


Хүснэгт 3 Активын үзүүлэлтүүд /сая.төгрөг/

Активын үзүүлэлтүүд	2021-III	Нийт дүнд	2022-III	Нийт дүнд	Өөрчлөлт	
	дүн	эзлэх хувь	дүн	эзлэх хувь	дүн	хувь
Эргэлтийн хөрөнгө	2,369,244.2	96.3%	3,294,186.2	96.9%	924,942.0	39.0%
Мөнгөн хөрөнгө	435,923.4	17.7%	401,993.4	11.8%	-33,930.0	-7.8%
Богино хугацаат хөрөнгө оруулалт (цэврээр)	19,065.9	0.8%	15,957.6	0.5%	-3,108.4	-16.3%
Зээл (цэврээр)	1,648,960.1	67.0%	2,524,028.7	74.2%	875,068.6	53.1%
Нийт зээл	1,765,925.5	71.8%	2,666,130.1	78.4%	900,204.6	51.0%
(Зээлийн эрсдэлийн сан)	116,965.3	4.8%	142,101.3	4.2%	25,136.0	21.5%
Факторингийн тооцооны авлага (цэврээр)	10,714.3	0.4%	10,355.5	0.3%	-358.8	-3.3%
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө (цэврээр)	12,414.1	0.5%	19,666.2	0.6%	7,252.2	58.4%
Бусад хөрөнгө	242,166.4	9.8%	322,144.1	9.5%	79,977.7	33.0%
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл (дериватив)-ийн авлага	0.0	-	40.6	0.0%	40.6	-
Эргэлтийн бус хөрөнгө	90,866.2	3.7%	106,607.0	3.1%	15,740.8	17.3%
Үндсэн (биет) ба биет бус хөрөнгө	115,618.7	4.7%	138,840.7	4.1%	23,222.0	20.1%
(Хуримтлагдсан элэгдэл)	-24,752.5	-1.0%	-32,233.7	-0.9%	-7,481.2	30.2%
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>2,460,110.4</b>	<b>100.0%</b>	<b>3,400,793.2</b>	<b>100.0%</b>	<b>940,682.8</b>	<b>38.2%</b>

Эх сурвалж: (СЗХ, 2022)

Сүүлийн 5 жилийн активын үзүүлэлтүүдийг харвал ББСБ салбарын нийт актив 2018 оны 3 дугаар улиралд 1.2 их наяд төгрөг байсан бол 2022 оны 3 дугаар улиралд 2.8 дахин өсөлт үзүүлж 3.4 их наяд төгрөгт хүрчээ. Энэхүү өсөлт нь цэвэр зээлийн үлдэгдэл 3.4 дахин өссөнтэй холбоотой юм.

График 1 Сүүлийн 5 жилийн активын үзүүлэлт /тэрбум төгрөг/



Эх сурвалж: (СЗХ, 2022)

ББСБ-ын нийт хөрөнгийн 2.5 тэрбум төгрөг ба түүнээс дээш хөрөнгөтэй 256 ББСБ буюу 89.4 хувь, 1.9 тэрбум төгрөгөөс 2.5 тэрбум төгрөг хүртэлх активтай 117 ББСБ буюу 7.4 хувь бол 1.9 тэрбум төгрөг хүртэлх активтай 149 ББСБ нь нийт ББСБ-ын хөрөнгийн 3.2 хувийг бүрдүүлж байна.

ББСБ-ын хамгийн өндөр активтай 20 ББСБ нь 1.7 их наяд төгрөгийн активтай байгаа нь нийт активын хэмжээний 50.1 %-ийг бүрдүүлж байна. Харин нийт зээлийн үлдэгдэлийн 52.7 хувийг нийт зээлийн үлдэгдэл 1.4 их наяд төгрөг бүрдүүлж байна.

• **Мөнгөн хөрөнгө**

Өмнөх оны мөн үеэс мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 7.8 хувиар буюу 33.9 тэрбум төгрөгөөр буурч 402.0 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй болсон байна. Бүтцээр нь авч үзвэл

банк болон санхүүгийн байгууллагын харилцах дансанд 41.8 хувь, бэлэн мөнгө хэлбэрээр 29.6 хувь, банк болон санхүүгийн байгууллагын хадгаламжийн дансанд 28.6 хувиа байршуулсан байна.

График 2 Сүүлийн 5 жилийн байдлаар мөнгөн хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөг/



Эх сурвалж: (СЗХ, 2022)

- **Богино хугацаат хөрөнгө оруулалт**

2021 оны 3 дугаар улиралаас 3.1 тэрбум төгрөг буюу 16.3 хувиар буурсан ба 2022 оны 3 дугаар улиралд 25 ББСБ 16 тэрбум төгрөгний хөрөнгө оруулалтын үлдэгдэлтэй гарсан байна. Богино хугацаат хөрөнгө оруулалт нь хөрөнгө оруулалтын үнэт цаасанд 8.5 тэрбум төгрөг буюу 53.6 хувь бол арилжааны үнэт цаас 7.5 тэрбум төгрөг буюу 47 хувийг бүрдүүлж байна. Төрөлжүүлж авч үзвэл хувьцаанд 11.7 тэрбум төгрөг буюу 73.1 хувь, өрийн бичгэнд 4.2 тэрбум төгрөг буюу 26.3 хувь, бусад үнэт цаасан дахь хөрөнгө оруулалт нь 186.1 сая буюу 1.2 хувь байна.

Хүснэгт 4 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц /сая.төгрөг/

	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
<b>БХХО (ЦЭВРЭЭР)</b>	15,957.6	14,524.7	8,793.6	7,164.0	1.0	15,182.3	775.3	9,300.4	6,279.4
Хувьцаа	11,669.7	10,246.8	8,282.6	3,387.1	1.0	10,894.4	775.3	8,114.9	5,878.4
Өрийн бичиг	4,201.0	4,201.0	501.0	3,700.0	-	4,201.0	-	1,009.4	401.0
Бусад	186.1	176.1	10.0	176.1	-	186.1	-	176.1	-
Хөрөнгө оруулалтын үнэт цаас	8,553.4	7,917.4	6,514.4	2,039.0	-	8,518.8	34.6	6,523.5	5,878.4
Арилжааны үнэт цаас	7,503.3	6,706.5	2,279.2	5,224.2	1.0	6,762.7	740.7	2,776.9	401.0

Эх сурвалж: (СЗХ, 2022)

- **Факторингийн тооцооны авлага**

2021 оны 3 дугаар улиралтай харьцуулахад 318.3сая төгрөг буюу 2.9 хувиар буурч, 10.5 тэрбум төгрөгний үлдэгдэлтэй 13 ББСБ байна. 2022 оны 3 дугаар улирлын байдлаар 155.6 сая төгрөгийн эрсдэлийн санг 509.5 сая төгрөгийн анхаарал хандуулах болон чанаргүй факторингийн үлдэгдэлийг 5 ББСБ байгуулж, 10.4 тэрбум төгрөгийн цэвэр үлдэгдэлтэй гарсан байна. Факторингийн тусгай зөвшөөрөлтэй ББСБ 43 болж өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн ч гэсэн 29 ББСБ факторингийн тусгай зөвшөөрөл олгосноос хойш энэ үйл ажиллагааг явуулаагүй байна.



## Хүснэгт 5 Факторингийн тооцооны авлагын ангилал /сая.төгрөг/

Нийт факторингийн тооцооны авлага	2021-III		2022-III		Өөрчлөлт	
	Нийт дүн 10,829.4	Эзлэх хувь 100.0%	Нийт дүн 10,511.1	Эзлэх хувь 100.0%	Дүн	Хувь
Хэвийн	10,190.0	94.1%	10,001.6	95.2%	(188.4)	-1.8%
Анхаарал хандуулах	319.2	2.9%	167.9	1.6%	(151.3)	-47.4%
Чанаргүй	320.2	3.0%	341.6	3.3%	21.5	6.7%
Хэвийн бус	275.7	2.5%	136.7	1.3%	(139.0)	-50.4%
Эргэлзээтэй	28.5	0.3%	183.8	1.7%	155.3	544.8%
Муу	16.0	0.1%	21.1	0.2%	5.2	32.3%
(Факторингийн авлагын эрсдэлийн сан)	115.1	1.1%	155.6	1.5%	40.5	35.2%

Эх сурвалж: (СЗХ, 2022)

- **Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө**

2021 оны 3 дугаар улиралтай харьцуулахад 58.4 хувь буюу 7.2 тэрбум төгрөгөөр өсөж 19.7 тэрбум төгрөгний үлдэгдэлтэй гарсан байна.

## Хүснэгт 6 ӨБҮХХ болон ӨБХ-ийн бүтэц /сая.төгрөг/

	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
<b>ӨБҮХХ БОЛОН ӨБХ (ЦЭВРЭЭР)</b>	19,666.2	7,762.5	16,091.6	3,574.6	19,094.7	571.5	335.0	19,331.2	1,399.9
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	23,343.2	10,023.9	16,604.7	6,738.4	23,195.2	148.0	2,121.1	21,222.1	2,496.0
(ӨБҮХХ-ийн болзошгүй эрсдэлийн сан)	8,702.6	5,294.9	5,463.8	3,238.8	8,702.6	-	1,786.1	6,916.6	1,697.5
Өмчлөх бусад хөрөнгө	5,025.7	3,033.5	4,950.7	75.0	4,602.2	423.5	-	5,025.7	601.4

Эх сурвалж: (СЗХ, 2022)

- **Зээл**

2021 оны 3 дугаар улиралтай харьцуулахад нийт зээлийн хэмжээ 900.2 тэрбум төгрөгөөр буюу 51 хувиар өсөж 2022 оны 3 дугаар улирлын байдлаар 142.1 тэрбум төгрөгний эрсдлийн сан байгуулсан ба 2,666.1 тэрбум хүрсэн юм. Цэвэр зээлийн 2,524.0 тэрбум төгрөгний үлдэгдэлтэй байна.

## Хүснэгт 7 Зээлийн бүтэц


	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
<b>ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)</b>	2,524.0	1,479.8	1,588.0	936.1	2,475.2	48.8	378.5	2,145.6	402.9
Нийт зээл	2,666.1	1,548.3	1,687.4	978.7	2,611.9	54.3	393.3	2,272.9	419.0
Хэвийн	2,360.3	1,397.8	1,485.6	874.7	2,313.3	47.0	360.5	1,999.9	383.7
Анхаарал хандуулах	111.1	57.9	68.0	43.0	110.0	1.1	11.6	99.5	11.6
Чанаргүй:	194.7	92.6	133.8	61.0	188.6	6.2	21.2	173.5	23.7
-Хэвийн бус	58.8	30.3	33.6	25.2	58.3	0.5	8.0	50.8	7.4
-Эргэлзээтэй	44.4	21.6	27.0	17.4	43.8	0.7	7.3	37.1	5.6
-Муу	91.5	40.6	73.2	18.4	86.6	5.0	5.9	85.6	10.7
(Зээлийн эрсдэлийн сан)	142.1	68.5	99.4	42.7	136.6	5.5	14.8	127.3	16.1
Нийт зээл (төгрөгийн)	2,589.8	1,489.8	1,642.0	947.8	2,535.8	54.0	364.6	2,225.1	384.9
Нийт зээл (валютын)	76.4	58.4	45.4	30.9	76.1	0.3	28.6	47.8	34.1
Зээлдэгчдийн тоо	1,644,423	644,657	325,855	1,318,568	1,626,718	17,705	209,842	1,434,581	136,369
- Иргэн	1,644,423	644,657	325,855	1,318,568	1,626,718	17,705	209,842	1,434,581	1,551,585
- Хуулийн этгээд	1,627	556	1,351	276	1,577	50	205	282	887

Эх сурвалж: (СЗХ, 2022)

Тайлант хугацаанд 3.1 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр 3.4 их наяд төгрөгийн зээлийг олгож, үүнээс эргэн төлөгдсөн нь 2.8 их наяд төгрөг ба 2022 оны 3 дугаар улирлын байдлаар 1.6 сая зээлдэгчийн 2.7 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.

Нийт зээлийн үлдэгдлийн хэвийн зээл нь 2.4 их наяд төгрөг буюу 88.5 хувь, анхаарал хандуулах зээл нь 111.1 тэрбум төгрөг буюу 4.2 хувь, чанаргүй зээл нь 194.7 тэрбум буюу 7.3 хувийг бүрдүүлж байна.

График 3 Зээлийн багцын чанар /тэрбум төгрөг/



Эх сурвалж: (СЗХ, 2022)


Нийт олгосон зээлийн иргэдэд 3.1 их наяд төгрөг буюу 92.1 хувь, хуулийн этгээдэд 269.4 тэрбум төгрөг буюу 7.9 хувийг олгосон байна. Мөн иргэдээс 2.5 их наяд төгрөг буюу 91.9 хувь, хуулийн этгээдэд 221.5 тэрбум төгрөг буюу 8.1 хувь нь эргэн төлөгдсөн байна.

Хүснэгт 8 Олгосон болон төлөгдсөн зээл салбарын ангилал /сая.төгрөг/

№	Зээлийн эдийн засгийн ангилал	Олгосон зээл		Төлөгдсөн зээл		Зээлийн үлдэгдэл	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1.	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	20,380.3	0.6%	17,108.7	0.6%	29,297.5	1.1%
2.	Уул уурхай, олборлолт	26,550.8	0.8%	28,565.3	1.0%	43,560.8	1.6%
3.	Боловсруулах үйлдвэрлэл	28,986.6	0.9%	25,583.5	0.9%	32,916.3	1.2%
4.	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	12,372.5	0.4%	2,009.1	0.1%	13,291.6	0.5%
5.	Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	2,030.7	0.1%	2,367.5	0.1%	2,088.9	0.1%
6.	Барилга	139,764.1	4.1%	115,799.7	4.2%	204,895.3	7.7%
7.	Бөөний болон жижиглэн худалдаа	287,249.3	8.5%	224,290.1	8.2%	323,656.3	12.1%
8.	Машин мотоциклийн засвар үйлчилгээ	96,072.3	2.8%	82,589.9	3.0%	98,777.8	3.7%
9.	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	36,748.2	1.1%	22,976.3	0.8%	37,577.6	1.4%
10.	Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	50,152.0	1.5%	37,647.0	1.4%	94,753.4	3.6%
11.	Мэдээлэл холбоо	7,729.1	0.2%	5,729.8	0.2%	8,720.2	0.3%
12.	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	59,510.8	1.8%	52,552.1	1.9%	40,120.6	1.5%
13.	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	8,475.4	0.2%	7,995.5	0.3%	15,665.8	0.6%
14.	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	2,305.4	0.1%	2,446.5	0.1%	4,922.0	0.2%
15.	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	19,805.4	0.6%	14,695.7	0.5%	21,243.5	0.8%
16.	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	1,421.6	0.0%	1,054.6	0.0%	1,658.9	0.1%
17.	Боловсрол	11,252.6	0.3%	8,233.4	0.3%	10,722.3	0.4%
18.	Хүний эрүүл мэнд, нийгмийн үйл ажиллагаа	12,404.6	0.4%	12,936.4	0.5%	13,157.6	0.5%
19.	Бусад	2,574,545.9	75.8%	2,060,667.3	75.6%	1,669,103.9	62.6%
Иргэнд олгосон зээл		3,128,385.1	92.1%	2,503,706.6	91.9%	2,369,194.5	88.9%
Хуулийн этгээдэд олгосон зээл		269,372.7	7.9%	221,541.5	8.1%	296,935.6	11.1%
<b>НИЙТ</b>		<b>3,397,757.8</b>	<b>100.0%</b>	<b>2,725,248.1</b>	<b>100.0%</b>	<b>2,666,130.1</b>	<b>100.0%</b>

Эх сурвалж: (СЗХ, 2022)

График 4 Олгосон зээл /хугацаагаар/



Энэхүү тайлант улиралд олгосон зээлүүдийг хугацааны ангиллаар харвал нийт 2.4 их наядын 1 жилээс 2.5 жилийн хугацаатай олгосон болон 6-1-сарын хугацаатай олгосон зээлүүд хамгийн их хувийг эзлэж байна.

Эх сурвалж: (СЗХ, 2022)

2.7 их наяд буюу нийт зээлийн үлдэгдлээс дүгнэхэд иргэнд олгосон хэрэглээний зээл 57.9 хувь, автомашинд зориулсан зээл 23.2 хувь, хуулийн этгээдэд олгосон бизнесийн зээл 9.1 хувиудыг тус тус бүрдүүлж байна.

### Цахим зээл

2022 оны 3 дугаар улирлын байдлаар 36 ББСБ онлайн зээлийн үйлчилгээг үзүүлж байна. Мөн 31 ББСБ нь финтек болон уламжлалт хослуулан ажиллаж, аппликэйшны зээлийг 5 ББСБ олгож байна. Уламжлалт зээл нь нийт зээлийн 87 хувийг цахим зээл нь 13 хувийг эзлэж байна. Цахим зээл нь 346.8 тэрбум төгрөгний үлдэгдэлтэй байгаа ба нэг зээлдэгч дунджаар 237.5 мянган төгрөгний зээл авдаг гэсэн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 9 Зээлийн ангилал


	Зээлийн дүн	Нийт дүнд эзлэх хувь	Зээлдэгчдийн тоо	Нийт дүнд эзлэх хувь	Дундаж зээл
Уламжлалт	2,319,320,999.5	87.0%	184,047	11.2%	12,601.8
Цахим зээл	346,809,088.7	13.0%	1,460,376	88.8%	237.5
<b>Нийт</b>	<b>2,666,130,088.2</b>	<b>100.0%</b>	<b>1,644,423</b>	<b>100.0%</b>	<b>1,621.3</b>

Эх сурвалж: (СЗХ, 2022)

### Ногоон зээл

Энэхүү тайлант хугацаанд 18 ББСБ-ын нийт 48.9 тэрбум төгрөгийн зээлийг 2490 зээлдэгчид дунджаар 2.6%-ийн хүүтэйгээр олгож, эргэн төлөгдсөн зээл нь 4789 зээлдэгчээс 19.7 тэрбум төгрөг байна. 2022 оны 3 дугаар улирлын байдлаар 21 ББСБ-ын 4102 зээлдэгчийн 78.3 тэрбум төгрөгний “ногоон зээл”-ийн үлдэгдэлтэй байна. ББСБ-ын гаргасан нийт зээлийн 2.9%-ийг эзлэж байна.

График 5 Ногоон зээлийн багцын чанар /ногоон таксономийн 8 ангиллаар/



Эх сурвалж: (СЗХ, 2022)

2021 оны жилийн эцсийн байдлаар 21 ББСБ 4,896 зээлдэгчийн 38.8 тэрбум төгрөгийн “ногоон” зээлийн үлдэгдэлтэй байсан бол тайлант хугацаанд буюу 2022 оны 3 дугаар сарын байдлаар 18 ББСБ 9.9 тэрбум төгрөгийг 2490 зээлдэгчид, зээлийг дунджаар 2.7 хувийн хүүтэйгээр олгож, 18 ББСБ-ын 19.7 тэрбум төгрөгийн зээл 4,789 зээлдэгчээс эргэн төлөгдөж, 2022 оны 3 дүгээр улирлын байдлаар 21 ББСБ 78.3 тэрбум төгрөгийн 4,102 зээлдэгчийн зээлийн үлдэгдэлтэй гарчээ. Ногоон зээлийн үлдэгдлийн хэвийн ангилалд 94.9 хувь, анхаарал хандуулах ангилалд 3.1 хувь, чанаргүй ангилал нь 1.9 хувь байна. Чанаргүй ангилалд хамгийн их зээлийн үлдэгдэлтэй салбар нь ногоон барилганы салбар байна.

- **Бусад хөрөнгө**

2022 оны 3 дугаар улирлын байдлаар нийт бусад хөрөнгийн үлдэгдэл 322.1 тэрбум төгрөг байгаа ба 119.9 тэрбум төгрөг буюу 37.2 хувь нь хуримтлууулж тооцсон хүүгийн авлага, 123.4 тэрбум төгрөг буюу 38.3 хувь нь дансны цэвэр авлага, 78.8 тэрбум төгрөг буюу 24.5 хувь нь бусад актив байна.

Хүснэгт 10 Бусад хөрөнгийн бүтэц /сая.төгрөг/


	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
БУСАД ХӨРӨНГӨ	322,144.1	168,979.3	233,792.0	88,352.1	215.8	316,923.2	5,220.9	51,738.4	49,847.1
Хуримтлууулж тооцсон хүүгийн авлага	119,887.5	57,230.3	92,250.8	27,636.7	-	118,103.0	1,784.5	9,951.9	19,166.7
-Үнэт цаасны	1,129.2	1,129.2	-	1,129.2	-	1,129.2	-	92.9	-
-Зээлийн	116,133.9	54,546.5	90,489.3	25,644.6	-	114,365.8	1,768.1	9,400.9	19,081.4
-Факторингийн	244.5	208.1	24.9	219.6	-	244.5	-	-	-
-Бусад	2,379.8	1,346.6	1,736.6	643.2	-	2,363.5	16.3	458.1	85.2
Авлага /цэврээр/	123,427.8	88,095.6	84,550.8	38,877.1	6.4	120,994.7	2,433.1	33,823.5	6,326.5
Нийт авлага	126,503.4	90,390.8	86,820.2	39,683.2	6.4	124,064.6	2,438.8	34,324.2	7,471.2
Хэвийн	120,442.4	87,856.1	81,683.7	38,758.7	2.9	118,017.1	2,425.3	33,811.6	6,505.1
Хугацаа хэтэрсэн	136.2	50.1	68.7	67.5	3.5	127.9	8.3	5.6	9.3
Чанаргүй:	5,924.8	2,484.6	5,067.9	856.9	-	5,919.5	5.2	507.1	956.7
-Хэвийн бус	56.7	50.0	11.7	45.0	-	56.7	-	5.3	7.5
-Эргэлзээтэй	49.8	48.1	6.0	43.8	-	49.8	-	5.4	5.3
-Муу	5,818.3	2,386.5	5,050.2	768.1	-	5,813.0	5.2	496.3	944.0
Нийт авлага (валютын)	100,840.3	65,281.9	61,776.1	39,064.2	6.4	98,401.5	2,438.8	34,317.1	7,471.1
Нийт авлага (төгрөгийн)	25,663.1	25,108.8	25,044.2	618.9	-	25,663.1	-	7.1	0.1
(Авлагын эрсдэлийн сан)	3,075.5	2,295.2	2,269.5	806.1	-	3,069.9	5.7	500.7	1,144.7
Бусад актив	78,828.8	23,653.4	56,990.5	21,838.3	209.4	77,825.5	1,003.4	7,962.9	24,354.0

Эх сурвалж: (СЗХ, 2022)

- **Ашигт ажиллагаа**

ББСБ нь 2022 оны 3 дугаар улирлын байдлаар орлого нь 624.8 тэрбум төгрөг, зардал нь 389.8 тэрбум төгрөг болж ашиг нь 235 тэрбум төгрөг болсон байна.

График 6 Ашигт ажилгааны үзүүлэлт /тэрбум төгрөг/



Эх сурвалж: (СЗХ, 2022)

2021 оны 3 дугаар улирлаас орлогын хэмжээ 270.6 тэрбум төгрөг буюу 76.4 хувиар, зардлын хэмжээ 183.4 тэрбум төгрөг буюу 88.8 хувиар, ашгийн хэмжээ 87.3 тэрбум төгрөг буюу 59 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Сүүлийн 2 жил цар тахалтайгаар холбоотой ашигт ажиллагаанд төдийлөн өсөлт үзүүлэхгүй байсан бол 2022 оны 3 дугаар улирлаас ББСБ-ын үндсэн үйл ажиллагаа нэмэгдэж үүнийгээ дагаад хүүгийн орлого болон шимтгэлийн орлого харгалзан 77.2 хувь болон 55.2 хувиар өсжээ.

## 3.2 Ногоон зээлийн өнөөгийн байдал

### 3.2.1 Олон улсын ногоон зах зээлийн өнөөгийн байдал

Ногоон зээл нь хүрээлэн буй орчны тогтвортой байдалд тулгуурласан шалгууруудыг хангасан тохиолдолд олгох зээлийг хэлнэ. Тогтвортой санхүүжилтийн томоохон хэсэг ба хүрээлэн буй орчинд эерэг нөлөөлөл үзүүлэх үйл ажиллагаа эрхлэгчдийг дэмжих зорилготой юм.

2005 оноос хойш АНУ-ын томоохон банкууд буюу Bank of America болон Wells Fargo нар ногоон зээлийг ашиглаж байсан. Тухайлбал тогтвортой хөгжлийн дэмжигч байгууллагуудыг дэмжиж 1 тэрбум долларын зээлийн 2005 оны 7-р сард Wells Fargo гаргаж байсан бол 20 тэрбум ам.долларыг 2007 оны 3-р сард Bank of America зээл болгон гаргаж байжээ. (Bank of America commits \$20 billion to Green lending)

Анх тогтвортой хөгжилтэй холбоотой өрийн үнэт цаас гаргалт 2013 онд болж байхад ногоон зээл, ногоон бонд гэсэн үндсэн 2 төрөлтэй байсан ба 2020 он дуусахад тогтвортой хөгжилтэй холбоотой өрийн үнэт цаас дэлхий даяар 6 төрөл болон анивчиж ээ.

1. Ногоон зээл
2. Ногоон бонд
3. Тогтвортой байдлын бонд
4. Нийгмийн бонд
5. Тогтвортой байдалтай холбосон бонд
6. Тогтвортой байдалтай холбосон зээл зэрэг орж байна.

Ногоон зээлийн зах зээлийн хэмжээ 2019 оны байдлаар 93.4 тэрбум доллар байсан ба 2020 онд 80.3 тэрбум болж буурчээ. Мөн 2019 оны байдлаар тогтвортой байдлын өрийн үнэт цаасны зах зээл 565.5 тэрбум доллар байсан бол 2020 он гэхэд 732.1 тэрбум болтлоо өсөлт үзүүлсэн байна. Ногоон бонд нь нийт өрийн үнэт цаасны хамгийн их хэмжээ буюу 41.7 хувийг дангаар эзэлж, ногоон зээл нь 11 хувийг эзэлжээ. Мөн ногоон зээлийг 5 салбар 90 хувийн бүрдүүлж байна.


Хүснэгт 11 Ногоон зээлийг хамгийн их хэрэглэдэг 5 салбар

Ногоон зээл	
Сэргээгдэх эрчим хүч	47%
Цахилгаан үүсгэвэр	23%
Хэрэгслүүд	8%
Үл хөдлөх хөрөнгө	6%
Санхүүгийн үйлчилгээ	3%

Эх сурвалж: (Nordea)

Мөн ногоон зээлийг хамгийн их хувийг Европын зах зээл 2015 оноос хойш манлайж яваа бол дараачаар нь Азийн зах зээл байдаг байна. Энэ хүү 2 зах зээл нь 2020 онд ногоон зээлийн зах зээлийн 80 хувийг бүрдүүлсэн байна. Дараачаар Америк, Африк болон Нордикийн улс орнууд ордог байна.

График 7 2015-2020 оны хоорондох Ногоон зээлийн бүсийн тархалт



Ази болон Ази Номхон далайн, Америкийн тогтвортой зээлийн ихэнх хэсгийг ногоон зээл эзэлж байна. Мөн ногоон зээлийг хэрэглэж буй бүс нутгийг салбараар нь авч үзвэл ихэнх хувийг эрчим хүч үйлдвэрлэх төслүүд болон сэргээгдэх эрчим хүчийг санхүүжүүлэх зорилгоор зээлдэг байна. Харин Нордик болон Европт зөвхөн эрчим хүч, сэргээгдэх эрчим хүчнээс гадна цахилгаан холбоо, химийн бодис, цаас, целлюлоз болон бусад төрлийн үйлдвэрлэл явуулдаг байна.

Ногоон зээлийн хөгжил дэвшлийг дэмжих зорилгоор ногоон зээлийн зарчмуудыг боловсруулсан ба боловсруулахдаа энэхүү зах зээлд хамгийн идэвхтэй ажилладаг тэргүүлэгч зээлдүүлэгчидтэй хамтарсан байна. Энэхүү зарчмууд нь ногоон зах зээл рүү чиглэсэн тогтвортой аргачлалыг санал болгох, удирдамж болон стандартыг бий болгох, мөн ногоон зээлийн бүрэн бүтэн байдал болн уян хатан байдлыг хадгалах зорилготой юм. Энэхүү зарчимд дөрвөн бүрэлдэхүүн хэсэгээр ногоон зээлийг тодорхойлдог.

1. Санхүүгийн менежмент: Ногоон зээлийн ил тод байдлыг хангаж, тодорхой дансанд бүртгэж, бүрэн байдлыг хангахын тулд зохих хяналтанд олгох хэрэгтэй.
2. Санхүүгийн ашиглалт: Ногоон зээлийн ашиглалт, зарцуулалтыг санхүүгийн баримт бичигт зааж өгөх хэрэгтэй. Энэхүү зээлийг хүсэж байгаа бүх төслүүд хүрээлэн буй орчинд үзүүлэх үр өгөөжийг баримтжуулж, баталгаажуулж байх хэрэгтэй. Үүнд зээлдэгчийн өөрийн үр дүн, таамагт тоон хэмжигдэхүүн ч багтсан байх хэрэгтэй.
3. Төслийг сонгох, үнэлэх үйл явц: Зээлдэгч энэхүү зээлийн зориулалтын талаар зээлдүүлэгчдэд тодорхой мэдээлэл өгсөн байх шаардлагатай. Түүний төсөл аль ангилалд багтах, зарчимуудад хэрхэн нийцэж байгааг шалгахын тулд, зээлдэгчийн төслөөс үүдэн гарч болох хүрээлэн буй орчны эрсдлийг тодорхойлох, ямар тохиолдол үүсвэл шалгуураас хасах зэргийг тодорхойлох үйл явц.

4. Тайлан гаргах: Зээлдэгч ногоон зээлийн санхүүжилтынхаа жил бүрийн мэдээлэлийг шинэчлэж, боловсруулж байх шаардлагатай. Мөн зарцуулалтын мэдээлэл, хэрхэн шат ахиж хөгжсөн талаар мэдээлэл боловсруулах шаардлагатай.

Олон улсад тавигдах ногоон зээлийн нөхцөлд эрчим хүчний хэмнэлттэй байдал, нүүрстөрөгийг багасгах, ундны усны аюулгүй байдал болон дахин ашиглалт, нарны зай хураагуур зэрэг зорилго тавьж энэхүү зорилго шаардлагыг хангаж байгаа төслүүдэд барьцаа болон барьцаагүйгээс хамааруулан 4.81 хувиас 7.99 хувь хүртэлх зээлийг 36 сараас 84 сар хүртэл олгодог байна. Зээлийн хэмжээ нь 3000 доллароос 15000 доллар, харин зээлдэгчийн насны хувьд 18-аас 60 хүртэл ба байнгын оршин суугч болон иргэн байх гэсэн нийтлэг шалгуур, нөхцлүүдийг тавьдаг байна.

### 3.2.2 Монгол улсын ногоон зээлийн өнөөгийн байдал

Манай оронд улсын хэмжээнд ногоон зээл болон ногоон зах зээлрүү шилжих хүрээнд тэрбум мод төсөл хэрэгжүүлж чадвал нийт цөлжсөн газар нутгийн 4%-ийг сэргээх, Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг 9% хүргэх, хүлэмжийн хийн ялгарлыг 600.000 тонноор буурлах үр дүнгүүдэд хүрнэ гэж байгаль орчин аялал жуучлалын яамнаас гаргажээ. Мөн 2030 он гэхэд монголын нийт банкны гаргаж байгаа зээлийн 10%-ийг ногоон зээл болгоно гэсэн зорилт тавьжээ. Мөн 2018 онд агаар орчны бохирдол бууруулах үндэсний хорооноос “Ногоон зээлийн сан” байгуулах төсөл санаачлагдсан ба энэхүү хүрээнд Монголын банкнуудын холбоотой хамтран арилжааны 3 банкттай сонгон шалгаруулсан. Энэ сонгон шалгаруултаас Хас банк, Хаан банк, Төрийн банк шалгаран 2018 оноос хойш зээл олгож эхэлсэн ба нийт 3 тэрбумын санхүүжилтийг тараан байршуулсан 2021 оны хагас жилийн байдлаар нийт 1.2 тэрбумын зээлийг олгосон байна. Монгол улсын хувьд 2021 онд ногоон зээлийн төрлийг нэмэж, шалгуур үзүүлэлтүүдийг багасгаж иргэд болон аж ахуй нэгжүүдэд илүү ээлтэй болжээ. 2018 онд ногоон зээлийн гэрээнд ААН-д 200 сая төгрөг хүртэлх, иргэдэд 50 сая төгрөг хүртэлх зээл олгоно гэж заасан тул арилжааны банкууд энэ заавраар олгодог байна. 12 сараас 60 сар хүртэл, хувийн эко нойлд 6 хувийн хүүтэй бусад бүтээгдэхүүнд 8 хувийн хүүтэй олгож байна. (Ногоон зээл, 2021)

Ногоон зээл авах боломжтой төслүүд:

1. Байгальд ээлтэй
2. Агаарын бохирдлыг бууруулах
3. Хөрсний бохирдлыг бууруулах зорилготой төслүүдэд олголт хийж байна.

Зураг 5 Ногоон зээлийн бүтээгдэхүүний зээлийн тоогоор



Эх сурвалж : (ОББҮХ, 2021)

Монгол орон дахь 2018 оноос 2021 оны хооронд жилийн дотор ногоон зээлийг 570 гаруй иргэд ААН авсан байна. Мөн энэхүү зээлийн олголтыг бүтээгдэхүүнээр нь ангилж үзвэл цахилгаан халаагуур, дулаалгын материал, эко ариун цэврийн байгууламж болон унадаг дугуйны зээл хамгийн их хувь буюу 88 хувийг эзлэж байна. Жишээлбэл эко ариун цэврийн байгууламж нийт ногоон зээлийн 21 хувийг эзлэж байгаа нь хөрсний бохирдол бууруулахад хамгийн их нөлөөтэй байгаа бол унадаг дугуйны зээл 32 хувь эзлэж байгаа нь агаарын бохирдол бууруулахаас гадна түгжрэл багасгахад ихээхэн хувь нэмэр оруулж байгаагийн илрэл билээ.

Одоогийн байдлаар дараах ББСБ-үүд доорх зориулалтаар тус тусын шимтгэл болон дээд хэмжээгээр олгож байна.

Хүснэгт 12 ББСБ-уудын ногоон зээлийн нөхцөл

№	Ногоон зээл олгогч ББСБ	Зээлийн төрөл	Шимтгэл	Зээлийн хүү /сар/	Зээлийн сар	Зээлийн дээд хэмжээ
1	БИД ББСБ	Орон сууц, объект	0.1%-0.3%	2.6%-2.99%	12-18 сар хүртэл	30 сая хүртэл
		Хашаа байшин				8 сая хүртэл
		Дан газар				3 сая хүртэл
2	Транскапитал ББСБ	Орон сууц, хашаа байшин худалдан авах, барих, засварлах	1% - 0%	3.95%-2.2%	60 сар хүртэл	1,000,000₮-500,000,000₮ хүртэлх
		Эко автомашин худалдан авах зээл	1% - 0%	2.65%	36 сар	Шинэ /гаалийн бичиг/ 100.000.000 ₮ Хуучин /дугаартай/ 50.000.000₮



		Дулаан шийдэл 2 төслийн зээл	1%	2.4% - 3%	24 сар	3 сая хүртэл
		Монгол гэрийн халаалт, дулаалга	1%	2%	30 сар хүртэл	4,000,000₮ хүртэл
3	Таван богд Финанс ББСБ	Ногоон автомашинны зээл	0.30%	2.5% - 2.7%	60 сар хүртэл	300 сая хүртэл
		Ногоон бизнес	0.30%	2.3% - 2.7%	60 сар хүртэл	300 сая хүртэл
4	Очир Ундраа ББСБ	Ногоон барилга бохирдлоос сэргийлэх	0%	2.00%	24 сар	10 сая

Эх сурвалж: (ББСБ болгоны албан ёсны хуудас)

Үүнээс үзэхэд ББСБ-үүдийн ногоон зээлийн төрөл нь эко автомашин, орон сууц, хашаа байшин болон дулаалга гэсэн 3 төрлийн зээл түлхүү олгож байна. Сэргээгдэх эрчим хүч, бохирдлоос сэргийлэх гэсэн зориулалттай ганц олгох ББСБ байгаа боловч зээлийн хэмжээ бусад зээлийг бодвол бага байна. Сэргээгдэх эрчим хүч өөрөө их санхүүжилт шаардлагатай салбар боловч маш бага санхүүжилт олгож байна. 2022 оны 3 сарын 29,30-ны өдрүүдэд МУ-ын ерөнхийлөгчийн санаачлагаар “ Ногоон санхүүжилт-бүс нутгийн чуулган” -аар газрын доройтол, цөлжилт, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах чиглэлээр бүс нутгийн хамтын ажиллагааг бататган, эрчимжүүлж, тогтвортой, ногоон санхүүжилтийг хөгжүүлэх, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, “ Ногоон хөгжлийн сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх тухай хэлэлцэн, зөвлөмж заавар гаргасан. Үүнээс дурдвал “ Ногоон зээлийг банкны салбарт 10%, ББСБ-уудад 5%-д хүргэхэд шаардлагатай бодлого боловсруулах болон хэрэгжүүлэх, ногоон зээлийн эх үүсвэрийн свопын зардлыг бууруулах, хөнгөлөлт урамшуулал олгох, эрсдэлийн санг байгуулах зэрэг хөшүүрэг бий болгох” үүргийг СЗХ хүлээсэн. Үүний дагуу энэ оны 2 дугаар улирлаас эхлэн “ МУ-ын ногоон таксономи” -ийн үндсэн 8 ангиллын дагуу ББСБ-уудаас “ногоон зээлийн тайлан” -г цуглуулаж эхлэсэн.

Энэхүү тайлант хугацаанд 18 ББСБ-ын нийт 48.9 тэрбум төгрөгийн зээлийг 2490 зээлдэгчид дунджаар 2.6%-ийн хүүтэйгээр олгож, эргэн төлөгдсөн зээл нь 4789 зээлдэгчээс 19.7 тэрбум төгрөг байна. 2022 оны 3 дугаар улирлын байдлаар 21 ББСБ-ын 4102 зээлдэгчийн 78.3 тэрбум төгрөгний “ногоон зээл”-ийн үлдэгдэлтэй байна. ББСБ-ын гаргасан нийт зээлийн 2.9%-ийг эзлэж байна.


## Хүснэгт 13 ББСБ-ны Ногоон зээлийн тайлан /сая төгрөгөөр/

НОГООН ТАКСОНОМИ ҮНДСЭН 8 АНГИЛАЛ	Олгосон зээлийн		Төлөгдсөн зээлийн		Зээлийн эцсийн үлдэгдлийн	
	Дүн	Зээлдэгчдийн тоо	Дүн	Зээлдэгчдийн тоо	Дүн	Зээлдэгчдийн тоо
1. СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ	-	-	-	-	-	-
2. БАГА БОХИРДУУЛАГЧ ЭРЧИМ ХҮЧ	-	-	124.0	2.0	125.0	1.0
3. ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ	-	-	2.0	1.0	5.1	6
4. НОГООН БАРИЛГА	1,915.8	185.0	1,077.7	77.0	6,358.1	825
5. БОХИРДЛООС СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	210.9	51.0	174.5	50.0	193.1	50.0
6. ТОГТВОРТОЙ УС, ХАЯГДЛЫН ХЭРЭГЛЭЭ	-	-	-	-	-	-
7. ТОГТВОРТОЙ ХӨДӨӨ АЖ АХУЙ, ГАЗАР АШИГЛАЛТ, ОЙ БОЛОН ЭКО АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ	16,684.5	9.0	264.6	5.0	16,970.4	13.0
8. КАРБОН БАГА ЯЛГАРУУЛДАГ ТЭЭВЭР	30,117.3	2,245.0	18,070.6	4,654.0	54,670.3	3,207.0
Үүнээс:						
0-5 хүртэлх жилийн ашиглалтын жилтэй тээвэр	58.5	4.0	12.0	5.0	122.8	2.0
5-10 хүртэлх жилийн ашиглалтын жилтэй тээвэр	22,276.2	1,480.0	12,632.8	3,531.0	34,290.7	1,868.0
10-аас дээш жилийн ашиглалтын жилтэй тээвэр	7,782.6	761.0	5,425.8	1,118.0	20,256.8	1,337.0
<b>НИЙТ</b>	<b>48,928.5</b>	<b>2,490.0</b>	<b>19,713.5</b>	<b>4,789.0</b>	<b>78,322.0</b>	<b>4,102.0</b>

Эх сурвалж: (frc.mn, n.d.)

Карбон бага ялгаруулдаг тээврийн хэрэгслийн зээлийн үлдэгдэл нь 54.7 тэрбум төгрөг ба нийт ногоон зээлийн 69.8 хувийг бүрдүүлж байна. Тогтвортой ус, хаягдлын хэрэглээ болон сэргээгдэх эрчим хүчний салбаруудад зээлийн үлдэгдэлгүй байна.

Зураг 6 Ногоон зээлийн багцын чанар /ногоон таксономийн 8 ангилалаар/



Эх сурвалж: (frc.mn, n.d.)

2021 оны жилийн эцсийн байдлаар 21 ББСБ 4,896 зээлдэгчийн 38.8 тэрбум төгрөгийн “ногоон” зээлийн үлдэгдэлтэй байсан бол тайлант хугацаанд буюу 2022 оны 3 дугаар сарын байдлаар 18 ББСБ 9.9 тэрбум төгрөгийг 2490 зээлдэгчид, зээлийг дунджаар 2.7 хувийн хүүтэйгээр олгож, 18 ББСБ-ын 19.7 тэрбум төгрөгийн зээл 4,789 зээлдэгчээс

эргэн төлөгдөж, 2022 оны 3 дүгээр улирлын байдлаар 21 ББСБ 78.3 тэрбум төгрөгийн 4,102 зээлдэгчийн зээлийн үлдэгдэлтэй гарчээ. Ногоон зээлийн үлдэгдлийн хэвийн ангилалд 94.9 хувь, анхаарал хандуулах ангилалд 3.1 хувь, чанаргүй ангилал нь 1.9 хувь байна. Чанаргүй ангилалд хамгийн их зээлийн үлдэгдэлтэй салбар нь ногоон барилганы салбар байна

### **Тогтвортой хөгжлийн холбоо**

Монгол улсад Тогтвортой санхүүгийн холбоо 2018 оны 1 сарын 1-ээс үйл ажиллагаагаа эхлүүлж, өдгөө 12 банк, 11ББСБ-г гишүүнээрээ элсүүлэн авсан байна. Гишүүн ББСБ:

- Нэт Капитал Финанс Корпораци ББСБ
- Транскапитал ББСБ
- Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалтын менежмент ҮЦК
- Гялс Кредит ББСБ
- Инвескор ББСБ
- Зээл Эм Эн Платформ ББСБ
- ЛэндМН ББСБ
- Жи Эс Би Капитал ББСБ
- Бизнес Инвест Девелопмент ББСБ
- Ард Кредит ББСБ
- Нөмөр ББСБ

Энэхүү байгууллага нь хүний эрх, байгаль орчин, ногоон эдийн засаг, соёлын өв, санхүүгийн ил тод байдал болон хүртээмж зэрэг өнөө үед бидэнд тулгамдаж буй чухал асуудлуудыг оролцуулан, санхүүжүүлж буй төслийнх нь нийгэм болон байгаль орчны эрсдлийг тодорхойлж, бууруулах, цаашлаад ногоон төслүүдийн хөрөнгө оруулалтын нэмэгдүүлэхэд банк болон ББСБ-ын гишүүн байгуулага нартаа дэмжлэг, чиглэл өгөх зорилготой юм. Өнөөдрийн байдлаар банк болон банк бус ТоС-ийн зарчмуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн байгаль орчин, нийгмийн өндөр эрсдэлтэй салбарууд буюу хөдөө аж ахуй, барилга, уул уурхай, боловсруулах үйлдвэр гэх мэт салбаруудад чиглэн, онцгой шаардлагуудыг тавин ажиллаж байгаа бөгөөд дэмжиж, зөвлөгөө өгж, сөрөг нөлөөллийг бууруулах талаар судлан хамтран ажиллаж байна.

### **3.3 Бүлгийн дүгнэлт**

Зөвхөн Монгол улсын хувьд гэлтгүй дэлхий даяар ногоон санхүүжилт нь бусад санхүүжилтаа бодвол “ногоон санхүүжилт” нь залуу салбар юм. Дэлхий даяар маш хурдан эрчээ авч үр дүнгээ өгч байна. Манай оронд анх банканд л ногоон зээл гардаг байсан бол одоо ББСБ ч гэсэн өөрийн хэмжээнд гаргадаг болсон байна. ББСБ-аас гарах ногоон зээлийн төрөл нь хашаа байшин, ногоон барилга, монгол гэрийн халаалт дулаалга гэх мэт санхүүжүүлж чадах болон эрсдэлээ даах хэмжээндээ ногоон зээлийн олголт хийгдэж байна. Мөн дэмжлэг авах болон зөвлөгөө үйлчилгээ өгөх “Тогтвортой хөгжлийн холбоо” байгуулагдаж, үүнд 12 ББСБ гишүүнээр элсүүлэн үйл ажиллагаагаа явуулж

байна. Ногоон зээл нь 2022 оны 1 дүгээр улиралд нийт ББСБ-ын зээлийн 1.8 хувийг эзэлдэг байсан бол 2022 оны 3 дугаар улирлын байдлаар 2.9 хувь болж өсөлт үзүүлжээ. Мөн энэхүү бүлгээр манай орны ББСБ болон ногоон санхүүжилт аль түвшинд байгааг илтгэхийг хичээлээ.

#### **IV БҮЛЭГ. ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭСЭГ**

##### **4.1 Яагаад Монгол улсад ногоон зээл, ногоон санхүүжилт шаардлагатай вэ?**

Монгол улсын уур амьсгалын өөрчлөлт:

Уур амьсгалын өөрчлөлт зөвхөн Монгол биш дэлхий даяар санхүүгийн систем болон эдийн засагт бодитой эрсдлийг бий болгож байна. Жишээлбэл уур амьсгалын өөрчлөлтөөс хамаарч олон нийтэд нээлтэй арилждаг үнэт цаастай компаниуд хувийн хэвшлүүдэд биет эрсдэл үүсэж байна. Мөн дэлхий даяар карбон их ялгаруулдаг бүхий салбаруудаас татгалзаж байгаа бөгөөд энэ нь нэг талаараа сул тал болох ч нөгөө талаараа боломж болно гэж дүгнэжээ. Ногоон шилжилтийг хийхэд бэрхшээлтэй хэдий ч энэ нь манай оронд эдийн засгийн өсөлт, өрсөлдөх чадварийг нэмэгдүүлэх ногоон ажлын байрыг бий болгох нөхцөлийг бүрдүүлж байна. Уур амьсгалын өөрчлөлтийг биет болон шилжилтийн эрсдэлийг үнэн зөв, бодитоор дүгнэн хэмжиж, тайлбарлахгүй байх нь монголын зах зээл, иргэдийн хадгаламж, компаниуд болон дотоодын санхүүгийн байгууллагын харилцагч нартаа үйлчлэх нөхцөлд аюул занал учруулах эрсдэлтэй. Тиймээс манай орны засгийн газар болон санхүүгийн зохицуулах байгууллагууд уур амьсгалын өөрчлөлттэй холбоо бүхий тодорхой санхүүгийн эрсдэлийг шийдвэр гаргалтад авч үзэх, макро зохистой байдлыг хэрэгжүүлэх замаар үлгэрчлэл үзүүлж, төсвийн болон хувийн хэвшлийн санхүүжилтийг хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах эсвэл зогсоох өндөр хэрэгцээ бий болоод байна. Мөн уур амьсгалын өөрчлөлтөөс улбаалан цаашид биет эрсдэл улам ихсэж, нэмэгдэх хүлээлттэй байна. Үүнээс улбаалан даатгалын компаниудын хувьд байгалийн үзэгдэл ихссээр байвал одоо даатгадаг зарим хөрөнгөө ирээдүйд даатгахгүй нөхцөлд хүрээд байна.

Банкны хувьд уур амьсгалын эрсдэлд тэсвэргүй бол тухайн үл хөдлөх хөрөнгийг зээлийн барьцаанд тооцож, зээлээ гаргахгүй эрсдэлтэй болно. Тооцсон тохиолдолд зээлийн барьцааны чанар муудаж, эрсдэл тохиолдсон үед зээл чанаргүйдэх, ашиг ажиллагаа буурах гэх мэт олон асуудал үүсэж болзошгүй. Жишээлбэл хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа эрхэлдэг зээлдэгч нарт уур амьсгалын өөрчлөлтөөс болоод ган тохиож, ургацын хэмжээ буурах, байгалын үзэгдэл тохиолдвол зээлдэгч төлбөрийн зөрчил үүсгэж болох эрсдэлтэй. Энэ мэт эрсдэлүүд санхүүгийн салбарыг тогтворгүй болоход нөлөөлж, улбаалан санхүүгийн систем болон макро эдийн засгийн тогтвортой хэтийн төлөвт муугаар нөлөөлөх аюул дагуулж байдаг.


Энэхүү шинжилгээнийхээ хүрээнд ногоон таксономигийн 8 үзүүлэлтийн хамгийн нөлөөтэй салбар мөртлөө санхүүжилт ерөөсөө авахгүй байгаа “Сэргээгдэх эрчим хүч” - ний салбарыг сонгон авч дүн шинжилгээгээ хийх болно. Үүгээр манай орны өнөөгийн

эрчим хүчний байдал болон сэргээгдэх эрчим хүчинд санхүүжилт олгосноор хэрхэн өөрчлөлт гарах талаар дүгнэх болно.

### 4.2 Монгол улсын эрчим хүчний өнөөгийн байдал

2022 оны 12 сарын 15 ны байдлаар манай орны эрчим хүчний оргил ачаалал 1462 МВт хүрсэн гэж эрчим хүч зохицуулах хорооноос мэдэгдсэн. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулвал 102 МВт-аар, импорт 166МВт-аар өссөн үзүүлэлттэй байна. Мөн манай улсын цахилгаан станцууд ямар нэгэн нөөц эрчим хүчгүйгээр ноогдох түвшингээс давсан хэмжээгээр ажиллаж байна.

Зураг 7 Монгол улсын эрчим хүчний системийн мэдээ




Эх сурвалж: (Эрчим хүчний зохицуулах хороо , 2022)

### 4.3 Сэргээгдэх эрчим хүчинд санхүүжилт хэрэгтэй шалтгаан:

Манай орны Өмнөговь аймагт нар болон салхин сэнсний сэргээгдэх эрчим хүчний станц байгуулснаар сэргээгдэх эрчим хүчний нөөц бололцоо АНУ-тай харьцуулж үзвэл 2.22 дахин их буюу 2.6Тераватт байна.

Зураг 8 Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх чадварын харьцаа Монгол болон АНУ




Эх сурвалж : (ELECTRICITY GENERATION CAPACITY , n.d.)

Эрчим хүчний салбар манай оронд ялгарч буй хүлэмжийн хийн гуравны хоёрыг ялгаруулдаг байна. Дотоодод судалдсан тооцооллоор энэ хэвээр цаашид үргэлжлэвэл 2030 он гэхэд 51.5 сая тонн нүүрстөрөгчийн давхар исэл болж нэмэгдэх ба эрчим хүчний салбарын нийт ялгаруулж буй хүлэмжийн хэмжээ 81.5%аар өсөх тооцоололтой байна. Иймд 2030 он хүртэл нүүрстөрөгчийн давхар исэлийг 7.3сая тонноор бууруулах зорилт тавьсан.

Дэлхий орон даяар болон манай оронд уур амьсгал болон байгаль орчны өөрчлөлтийн нөлөө болон хүн амын тоо нэмэгдэж байна. Үүнтэй холбоотойгоор өнөө үед нүүрсээр ажиллах цахилгааны болон дулааны станцууд шинээр барих хүчин чадлыг өргөтгөж, ихэсгэхэд санхүүжилтийн асуудал улам бүр хүндрэлтэй бөгөөд хумигдмал болж байна. Нөгөө талаас цахилгаан болон дулааны эрчим хүчний эрэлт хэрэгцээ өдрөөс өдөрт нэмэгдсээр байна. (Эрчим хүчний зохицуулах хороо, 2019)

Байгалийн эрчим хүч буюу нар, салхи, усыг хамгийн сайн сэргээгдэх эрчим хүч болгон ашигладаг улс бол БНХАУ юм. Дэлхийн хамгийн том салхин парк говь цөлд байрладаг.

Зураг 9 Говь цөлийн байршил



Эх сурвалж: (Сэргээгдэх эрчим хүчний туршлага, 2019)

Говь цөлийн газар нутгийн хэмжээгээрээ БНХАУ-тай бараг тэнцүү хэмжээтэй тул манай орон ч гэсэн дэлхийн хамгийн том салхин паркыг байгуулах боломжтой гэсэн үг. Энэхүү парк нь 8 ГВт-ын хүчин чадалтай 7000 ширхэг салхин сэнстэй ба одоогоор түүнээс үйлдвэрлэж болох нийт эрчим хүчнийхээ 50%-ийг ашиглаж байна. Хятад улсын хэмжээнд нийт 163ГВт хүчин чадал бүхий салхин сэнс суулгасан байгаа бол манай оронд өнөөгийн байдлаар 0.2ГВт бүхий салхин станцтай байна. Дэлхий дээр байгаа нийт салхин сэнсний 3 салхи сэнс тутамын нэг нь хятад улсад байрлаж байна. Үнэ нь жил ирэх тусам буурч байна.

Мөн нарны панель буюу нарны цахилгаан үүсгэвэр нь 135ГВтын хүчин чадалтай ба дэлхийн хамгийн том нарны цахилгаан станц мөн адил БНХАУ-ын хойд хэсэг буюу Татон мужид байрладаг байна. (Сэргээгдэх эрчим хүчний туршлага, 2019)

Хятад улсын хувьд 2017 онд нийт эрчим хүчний 26 хувийг ногоон эрчим хүчнээс гаргаж авсан бол 2050 он гэхэд энэ хэрэглээгээ 80 хувь болгож нүүрсний хэрэглээгээ эрчимтэй бууруулна гэсэн зорилт дэвшүүлсэн байна. Ази тивийн оронуудтай Монгол

орныг харьцуулвал Хятад улстай тэнцүү хэмжээнд сайн хөгжүүлж чадвал түүнээс ч их боломжит газар бөгөөд сэргээгдэх эрчим хүчийн экспортын орон болох боломжтой юм.

Монгол оронд 2,600 ГВт салхи, нарны эрчим хүчний эх үүсвэрийг суурилуулж ашиглан, хэрэглээндээ нэвтрүүлэх боломжтой. Энэ нь жилд 5,457 тераватт-цаг байгальд ээлтэй цэвэр эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадал юм. Энэхүү эрчим хүчийн нөөцөөр дотоодын хэрэглээг (2018 оны байдлаар 1.2ГВт орчим) бүрэн хангаад зогсохгүй эрчим хүч дамжуулах дэд бүтэц, төлөвлөгөөг оновчтой тодорхойлж шийдсэн тохиолдолд Зүүн хойд Азийн бүс нутгийн эрчим хүчний эрэлтийг хангах нөхцөл бүрдэх юм. Төрөөс эрчим хүчний талаар 2015-2030 он хүртэл баримтлах бодлогын хүрээнд эрчим хүчний системийн нийт суурилагдсан хүчин чадалд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь хэмжээг 2023 онд 20%-д, 2030 онд 30%-д тус тус хүргэж нэмэгдүүлэх зорилт тавьсан. (эх сурвалж: (Asian Development Bank, 2020))

#### 4.4 Олон улсад ББСБ-ийн ногоон зээлийн нөхцөл болон тавигдах шаардлага

Манай оронтой газрын байршил ойролцоо, хөгжиж буй орон болон бусад шинжүүдийг харгалзан бусад улсын орны банк бус санхүүгийн байгууллагуудын ногоон зээлийн нөхцөл болон хүү шимтгэлийн талаар судаллаа.

- **Hattha Kaksekar Limited (Камбож улс) ногоон зээл**

Био боловсруулах үйлдвэр, нарны эрчим хүч, усны шүүлтүүр, ариун цэврийн байгууламж гэх мэт ногоон эрчим хүчээр амьжиргааны түвшингээ дээшлүүлэх хүсэлтэй хүмүүст тохиромжтой байна.

Хүснэгт 14 Ногоон зээлийн нөхцөл (Камбож улс)

Нөхцөл	
Валют	KHR, USD, THB
Хугацаа	24 сар
Зээлийн дээд хэмжээ	2500 доллар
Хүү	1.5% хүртэл
Төлбөрийн нөхцөл	уян хатан

Эх сурвалж: (Hattha Kaksekar limited, 2022)

Шаардлага

- Камбож улсын иргэн байх
- NKL компаний үйл ажиллагаа явуулдаг бүсийн байнгын оршин суугч байх
- Хууль зөрчөөгүй ажил мэргэжилтэй байх
- Гэмт хэргийн түүхгүй байх
- Иргэний үнэмлэх болон өмчлөх эрхийн гэрчилгээ нь тухайн хүнийх байх

Манай оронтой ижил төсөөтэй орны ББСБ өөрийн ногоон зээлийн төрөлдөө сэргээгдэх эрчим хүчний бүтээгдэхүүнийг багтаан оруулж үйл ажиллагаагаа эрхлэж байна. Үүгээр манай орны ББСБ ч гэсэн энэхүү бүтээгдэхүүнийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх боломжтой гэж дүгнэж байна.



#### 4.5 Монгол дахь ББСБ-ийн ногоон зээлийн судалгаа

Энэхүү судалгааг тухайн ББСБ-ын эрхлэгчтэй нь уулзаж ярилцлага хэлбэрээр авсан ба эрхлэгч нь нэрээ нууцлах хүсэлт тавьсан тул цаашид “А ББСБ” гэж нэрлэлээ.

А ББСБ нь ногоон зээлийг 2016 оноос олгож эхэлсэн ба бусад ББСБ-ээс илүү олон төрөлтэй болон хүүний уян хатан байдлаар ногоон зээлээ олгохыг эрмэлздэг. Одоогоор монгол гэрийн дулаалга, экомашин, хашаа байшингийн засвар дулаалга гэх мэт ногоон зээлийг олгож байна. Цаашид төрөлөө нэмэх хүсэлттэй байгаа тул судалгаа хийгдэж байна. Энэ төрлийн зээлүүдийг олгохдоо тухайн үйл ажиллагаа явуулдаг компаниудтай хамтын ажиллагаа явуулдагаараа давуу талтай. Жишээлбэл монгол гэрийн дулаалганы үйл ажиллагаа явуулдаг компанитай хамтын ажиллагааны гэрээтэй ба тухайн компани нь А ББСБ-ын харилцагч нарт хөнгөлөлттэй үнээр бүтээгдэхүүнээ санал болгодог бол А ББСБ нь тухайн компани харилцагч нарт таатай нөхцөлтэй зээл олгодог байна. Ногоон зээл нь хүү бага, ашгийн төлөө бус тул хүү дотроо зардлаа л шингээж оруулдаг ба бусад бүтээгдэхүүнээрээ ашигаа олох боломжтой юм. Ногоон зээлийн нь нийгэмд олон давуу талуудыг авчирдаг байна.

- Озоны давхаргын цооролтын нөлөөллийг багасгах
- Азотын хий багасах
- Анх зөвхөн ногоон бүтээгдэхүүнд зардал гаргасан байхад цаашид гарах зардал энгийн бүтээгдэхүүнтэй харицуулахад бага
- Улс орны хувьд хөгжүүлснээр цаашид өөр улсад экспортлох боломжтой
- Байгаль орчин нийгэмд ээлтэй
- Дахин боловсруулах боломжтой тохиолдолд хог хаягдал багасгана.

Ногоон зээл нь нийт зээлийн 30 хувийг эзэлдэг ба үүний тал хувийг ногоон машины зээл эзэлдэг байна.

Ногоон зээл анх олгохдоо олон улсын байгууллагатай хамтарч ажилладаг байсан. Энэхүү байгууллагаасаа техник технологийн сургалт авж мэдлэг хуримтлуулж өөрсдөө санхүүжилтаа гаргадаг. Олон улсын томоохон байгууллагатай хамтарснаар дараах давуу талууд байдаг:

- Олон улсын туршлагаар ажилчдаа сургах боломж өндөр
- Олон улсын туршлагаас хоцролгүй, дэлхийтэй хөл нийлүүлэн алхах боломжтой
- Олон улсын томоохон компанитай хамтарч ажилснаар дараагийн олон улсын компанитай хамтран ажиллахад илүү хялбар болно.
- Эрсдэл тулгарсан тохиолдолд хамгийн шуурхай зөв аргыг авах боломжтой гэх мэт давуу талууд байдаг.

Энэхүү зээлийг олгохдоо анхаарах зүйл нь зорилтот хэрэглэгчээ хамгийн сайн тодорхойлж яг тухайн хэрэглэгч нартаа хүргэж чадаж байгаа эсэхэд сайн анхаарах хэрэгтэй. Мөн сард яг хэдэн төгрөгийн зээлийг ногоон зээлд гаргах шаардлагатайгаа сайн тодорхойлж чадвал зардалаа нөхөж чадахаас гадна яг тэр хэмжээндээ гаргасан тохиолдолд ашиг олох боломжтой байдаг байна. Гэхдээ энэхүү бүтээгдэхүүний ганц эрсдэл нь зээл чанаргүйтэх байдаг ба энэ зээлийг авсан хүмүүсийн хувьд харьцангуй бага байдаг. Учир нь хүмүүс бага хүүтэй зээл буюу илүү хямд төсвөөр амьдрах орчиноо сайжруулдаг болохоор түүндээ урамшиж зээлийн төлөлтөө алдалгүй төлдөг байна.

А ББСБ цаашид бүтээгдэхүүний төрөлөө нэмж илүү олон компанитай хамтын ажиллагааны гэрээ байгуулж үйлчлүүлэгчиддээ төрөл олон бүтээгдэхүүн санал болгох зорилттой. Мөн бүтээгдэхүүнээсээ шалтгаалж хүүний уян хатан байдал нь харилцагч болон компани хоёуланд нь ашигтай байж чаддаг. ББСБ нь банкнаас ялгарах онцлогууд

нь үйлчлэгчиддээ түргэн шуурхай зээлийн олгодог ба хэт баригдмал биш, цаашид илүү цогцоор нь төрөлжүүлэх боломжтойгоороо давуу талтай байдаг.

Цаашид сэргээгдэх эрчим хүчний салбарт ногоон зээл олгодог болвол хамгийн том эргэлтийг авчирна. Жишээлбэл зуслангийн байшиндаа тогны утас холбуулах зардал нь нийтдээ 20 сая орчим болж байсан. Гэхдээ энэ 20 саяаар сэргээгдэх эрчим хүч ашиглаж зуслангийн байшиндаа тогтой болвол цаашид гарах тогны зардал маань бараг байхгүй болно. Цахилгаан станц нь аюултай түвшиндээ ажиллаж байгаа энэ үед хамгийн хэрэгтэй зүйл юм. Үүний хүрээнд харилцагчиддаа илүү тав тухтай болон хурдан шуурхай цогц үйлчилгээг санал болгох тал дээр илүү түлхүү ажиллаж байна.

#### 4.6 Ногоон зээлийн гадаад эх үүсвэрүүд (Сэргээгдэх эрчим хүч)

Энэхүү хэсэгт манай орны ББСБ-ууд сэргээгдэх эрчим хүчийн зориулалттай олон улсаас татаж болох боломжтой эх үүсвэрүүдийг хүү нөхцөл тавигдах шаардлагын хамт судлав. Олон улсын дараах сангууд нь сэргээгдэх эрчим хүчний нөөц бололцоо өндөр улс орнуудад хөрөнгө оруулах сонирхолтой юм. Мөн төлбөрийн болзол нь янз бүр ба төслөөс хувь эзэмших эсвэл өөрсдөө тухайн төслийг хэрэглэгч нь байх гэдэг бол зарим нь буцалтгүй тусламж байх ч тохиолдол байдаг байна.

### 1. Эрчим хүчний салбарын менежментийн туслалцааны хөтөлбөр (Energy Sector Management Assistance Program)

Эрчим хүчний салбарын менежментийн туслалцааны хөтөлбөр нь дэлхийн банкнаас санаачлан удирддаг дэлхийн мэдлэгийг тэлэх зорилготой техникийн туслалцааны хөтөлбөр юм. Энэ нь эдийн засгийн өсөлтийг дэмжих, хөгжил буурай байдлыг бууруулах, хүрээлэн буй орчиндоо ээлтэй эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлхийн тулд дунд болон бага орлоготой орнуудад арга туршлага болон институцийн чадварыг нэмэгдүүлэхэд санхүүгийн болон зөвлөх үйлчилгээ үзүүлнэ.

Зураг 10 2030 он гэхэд хүрэх олон улсын амлалт



Эх сурвалж: (Energy Sector Management Assistance Program , 2022)

**Сангийн хэмжээ :** 1.3 тэрбум ам.доллар

**Зорилго:** Институцын чадавх бүрдүүлэх, таатай орчин бүрдүүлэх

**Зорилт:** Сааруулах

**Хөрөнгө оруулах салбар:**

- Утаагүй зуух
- Сэргээгдэх эрчим хүч
- Цахилгаан эрчим хүчний хангамж
- Карбонгүйжүүлэх

**Санхүүжилтийн хэлбэр :** Буцалтгүй тусламж

## 2. Цэвэр технологийн сан (CTFPF)

Энэхүү сан нь уур амьсгалын хөрөнгө оруулалтын сангийн нэг хэсэг юм. Нүүрстөрөгч бага ашиглалттай хүлэмжийн хийн ялгаруулалтыг урт хугацаанд хэмнэх боломжийг нэвтрүүлэх, хөгжүүлэх, шилжүүлэхэд нөлөөлж болохуйц хөгжиж буй орнуудад хөрөнгө оруулдаг.

**Сангийн хэмжээ :** 2900 сая ам.доллар

**Хамрах хүрээ:** Үндэсний, Бүсийн , дэд нэгж, салбарын хэмжээний төслүүд

**Зорилт:** Сааруулах

**Хөрөнгө оруулах салбар:**

- Сэргээгдэх эрчим хүч
- Тээвэр

**Санхүүжилтийн хэлбэр:** Хөнгөлөлттэй зээл, Буцалтгүй тусламж

*Эх сурвалж: (climate investment funds , 2022)*

## 3. Дэлхийн уур амьсгалын хамтын ажиллагааны сан (Global Climate Partnership Fund )

Энэхүү сан нь сонгондсон улс орнуудтай хамтран тухайн улсын уур амьсгалтай холбоотой төслүүдэд хөрөнгө оруулах шинэлэг санхүүжилтийн хэрэгсэл юм. Энэ сан нь тухайн улсын санхүүгийн байгууллагуудыг зээлийн шугамаар хангах бөгөөд сонгогдсон байгууллагууд нь хүлэмжийн хийг бууруулах, эрчим хүчний хэмнэлт, сэргээгдэх эрчим хүчинд хөрөнгө оруулалт хэлбэрээр гаргах ба зээл хэлбэрээр гаргана. Мөн нэмэлт санхүүжилт шаардлагатай үед дотоодын төрийн болон хувийн хэвшлээс татах замаар тодорхой хэсгийн төсвийн хөрөнгийг хөшүүрэгдэнэ. Сэргээгдэх эрчим хүч болон эрчим хүчний ашигтай хэрэглээг сурталчлах замаар энэхүү сан нь хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад том хувь нэмэр оруулдаг.

**Сангийн хэмжээ:** 504 сая ам доллар

**Хамрах хүрээ:** Иргэний нийгмийн байгууллагууд болон хувийн хэвшил

**Зорилт:** Дасан зохицох

**Хөрөнгө оруулах салбар:**

- Сэргээгдэх эрчим хүч
- Эрчим хүчний төслүүд
- Эрчим хүчний хэмнэлт

**Санхүүжилтийн хэлбэр:** Хөнгөлөлттэй зээл болон хөрөнгө оруулалт

*Эх сурвалж: (Global Climate Partnership Fund, 2022)*

Энэ мэтчилэн манай орны ББСБ-ууд хамрагдаж болох олон сайн дурын хөрөнгө оруулалтын сангууд байдаг.

**4.7 Банкны ногоон зээлийг ББСБ-тай харьцуулах**

Хүснэгт 15 Банкнуудын ногоон зээлийн нөхцөл

№	Банк	Зээлийн төрөл	Жилийн хүү	Зээлийн хэмжээ	Зээлийн сар
1	Хаан	Монгол гэр	3%	5 сая ₮ хүртэл	30 сар хүртэл
		Амины орон сууц болон хашаа байшин	3%	40 сая₮ хүртэл	30 сар хүртэл
		Стандартын шаардлага хангасан жорлон	2%	40 сая₮ хүртэл	30 сар хүртэл
2	ХАС	Халаагуурын Эко хэрэглээний зээл	3%	50 сая₮ хүртэл	30 сар хүртэл
		Агаар орчны бохирдлыг бууруулахад чиглэсэн хэрэглээний ногоон зээл	3%	50 сая₮ хүртэл	30 сар хүртэл
		Chip багц төслийн зээл	3%	3.2 сая ₮	30 сар хүртэл
3	ХХБ	Бизнесийн ногоон зээл	15%	Төслөөс хамаарч хэмжээг сонгоно	36 сар
4	Голомт	Хөрөнгө оруулалтын зээл	14.40% - 16.80%	1 тэрбум ₮ хүртэл	84 хүртэл сар
		Эргэлтийн хөрөнгийн зээл	14.40% - 16.80%	500,0 ₮ хүртэл	30 сар хүртэл
5	Төрийн Банк	цахилгаан халаагуурын зээл	3%	10 сая ₮ хүртэл	30 сар хүртэл
		Дулаалгын материалын зээд	3%	15 сая₮ хүртэл	30 сар хүртэл
		Эко ариун цэврийн байгууламж	2%	10 сая ₮ хүртэл	30 сар хүртэл
		Сайжруулсан зуухны зээл	3%	3 сая ₮ хүртэл	30 сар хүртэл
		Эко автомашин 100% цахилгаан хөдөлгүүрт	3%	50 сая₮ хүртэл	30 сар хүртэл
		Цахилгаан скүүтер	3%	51 сая₮ хүртэл	30 сар хүртэл
		Унадаг дугуй	3%	52 сая₮ хүртэл	30 сар хүртэл
Эко ариун цэврийн байгууламж худалдан авах болон суурилуулах	8%	10 сая ₮ хүртэл	30 сар хүртэл		

		Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн төхөөрөмж худалдан авах болон суурилуулах	8%	100 сая ₮ хүртэл	30 сар хүртэл
		Мод бут болон ногоон байгууламж байгуулах	8%	10 сая ₮ хүртэл	30 сар хүртэл
		Хөргөлтийн тоног төхөөрөмж худалдан авах	8%	100 сая ₮ хүртэл	30 сар хүртэл
		Агаар цэвэршүүлэгч тоног төхөөрөмж худалдан авах	8%	30 сая ₮ хүртэл	30 сар хүртэл
6	Ариг банк	Эко автомашин	16.8% - 20.4%	50 сая ₮ хүртэл	48 сар хүртэл
7	Богд	Ногоон хэрэглээний зээл	20.4% - 24%	10 сая ₮ хүртэл	30 сар хүртэл
8	Ни Банк Үндэсний хөрөнгө оруулалтын банк	-	-	-	-
9	Тээвэр хөгжлийн банк	-	-	-	-
10	Капитрон банк	Саарал усны тоног төхөөрөмжийн зээл	12% - 14.4%	Худалдаж авах тоног төхөөрөмжийн үнийн дүн	60 сар хүртэл
		Ногоон бизнесийн зээл	Тухайн цаг үед мөрдөгдөж байгаа бизнесийн зээлийн хамгийн бага хүүгээр тооцно.	Бизнесийн цар хүрээнээс хамаарна	60 сар хүртэл
		Хосолсон хөдөлгүүрт автомашины зээл	18%	Тухайн машины үнийн дүнгээс хамаарна.	30 сар хүртэл
		"Ногоон үндэс" цахилгаан автомашины зээл	12%	20 сая төгрөг хүртэл	12 сар хүртэл
			15%		30 сар хүртэл
		Хэрэглээний худалдан авалтын ногоон зээл	12%	10 сая ₮ хүртэл	12 сар хүртэл
15%	30 сар хүртэл				
11	Чингис хаан банк	-	-	-	-

Эх сурвалж: (Банк болгоны албан ёсны хуудас)

Манай улсад нийт 11 банк байдаг ба 8 компани нь Монгол банкны таксономи дагуу үйл ажиллагаагаа явуулдаг байгуулагт зориулсан ногоон зээлийг олгодог байна. Үүнээс хамгийн түгээмэл зээл нь экомашинны зээл болон хэрэглээний ногоон зээл байгаа бол ганцхан сэргээгдэх эрчим хүчтэй холбоотой зээлийг төрийн банк олгож байна. Банк бол ББСБ-аас арай бага хүү санал болгодог ч илүү их шаардлага тавьдаг. Жишээлбэл банк зээл олгоходоо нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн авч үздэг бол ББСБ орлогын нотолгоо хангалттай байх тохиолдол байдаг. Банк зээл олгоходоо ихэвчлэн дараах шаардлагыг тавьдаг байна. Үүнд:

- Монгол улсын иргэн, Монгол улсын нутаг дэвсгэрт бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг, Монгол улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж байх
- Сүүлийн 24 сараас доошгүй хугацаанд тогтвортой бизнес эрхэлж байгаа бөгөөд цаашид ч эрхлэх
- Банкны шаардлага хангахуйц барьцаа хөрөнгөтэй байх
- Банк болон ББСБ-аас авсан зээл нь муу ангилалд ангилагдсан түүхгүй байх
- Банкны шалгуур болох санхүүгийн харьцаануудыг зохих түвшинд хангасан байх
- Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэлгүй байх
- Монгол банкны Ногоон Таксаномид бизнесийн үндсэн үйл ажиллагааны чиглэл нь багтсан байх
- Зээлийн зориулалт болон бизнесийн үйл ажиллагаа нь БОНЭҮ-р “бага эрсдэлтэй” гарсан байх
- Эрсдэлийн түвшингөөс нь хамааран Банкны орчин нийгмийн эрсдлийн үйнэлгээний дотоод журмын Ногоон шаардлагыг биелүүлсэн байх
- Зээл зарцуулах бизнесийн үйл ажиллагааны чиглэл нь банкны БОНЭҮ-ний журамд тусгагдсан “Хориотой болон Анхааруулах үйл ажиллааны жагсаалт”-д багтаагүй байх
- Цалингийн орлоготой бол сүүлийн 12 сараас доошгүй хугацаанд тухайн байгууллагад ажилласан байх
- Бизнесийн орлоготой бол тухайн бизнесийн сүүлийн 12 сарын хугацаанд тогтвортой эрхэлсэн байх
- Банк шаардсан тохиолдолд хөрөнгө барьцаалах, хамтран үүрэг гүйцэтгэгчтэй байх, даатгуулах боломжтой байх
- Бизнесийн орлогыг тодорхойлох боломжтой байх

Энэ мэтчилэн нийт банкны ногоон зээл хүсэгчид тавьдаг ерөнхий зээлийн шаардлага байна. Энэхүү банкны шаардлагыг хангасан зээлдэгчид хангаагүй зээлдэгчээсээ цөөхөн байдаг.

#### **4.8 Хууль зүйн зохицуулалт**

Сэргээгдэх эрчим хүчний хууль санаачилж баталсан ба энэхүү хуулийн агууллага нь сэргээгдэх эрчим хүч ашигласнаарх эрх үүргийг зохицуулах юм. Энэ хууль нь нийт 6 бүлэг 15 дугаар зүйлтэй юм.

Нэгдүгээр бүлэг – Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

2 дугаар зүйл. Хууль тогтоомж

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

4 дүгээр зүйл Хуулийн нэр томъёо

Хоёрдугаар бүлэг – Төрийн байгууллагын бүрэн эрх

5 дугаар зүйл. Сэргээгдэх эрчим хүчний талаархи төрийн байгууллагын чиг үүрэг

### Гуравдугаар бүлэг – Тусгай зөвшөөрөл

6 дугаар зүйл. Сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр барих

7 дугаар зүйл. Сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл

8 дугаар зүйл. Диспетчерийн үндэсний төвийн үүрэг

9 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл авах

10 дугаар зүйл. Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ

### Дөрөвдүгээр бүлэг – Үнэ тариф

11 дүгээр зүйл. Сэргээгдэх эрчим хүчний үнэ, тариф

12 дугаар зүйл. Үнэ, тарифын үйлчлэх хугацаа

### Тавдугаар бүлэг – Сэргээгдэх эрчим хүчний сан

13 дугаар зүйл. Сэргээгдэх эрчим хүчний сан (энэхүү бүлгийг 2015 оны 1 дүгээр сарын 23ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон.)

### Зургадугаар бүлэг

14 дүгээр зүйл. Маргаан шийдвэрлэх

15 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

*Эх сурвалж: (Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем , 2007)*

Дээрх байдлаар хуулийн ангилал нь хуваагддаг ба тулгарч болзошгүй бүхий л асуудалд тулгуурлан баталсан байна. Энэ хуулийн хүрээнд сэргээгдэх эрчим хүчний үйл ажиллагаа явагдах болно.

## **4.9 ББСБ бичил байгууллага болон иргэдэд санал болгож болох бүтээгдэхүүний жагсаалт:**

- Сэргээгдэх эрчим хүчний технологи болон эрчим хүчний хэмнэлтийн судалгаа туршилт
- Сэргээгдэх эрчим хүчний технологийг нутагшуулах, хөгжүүлэх төсөл
- Дээврийн нарны фото цахилгаан үүсгэвэр
- Нарны вакуум коллектар буюу халаалтын систем
- Нарны агаар халаагуур
- Дулаан хуримтлуулалттай цахилгаан халаагуур
- Дулаалгын технологи
- Нарны зайн дэлгэц технологи

*Эх сурвалж: (Mongolian National Broadcaster , 2019)*

Дээрх худалдаж авах экологид эерэг нөлөөлөлтэй эрчим хүчний системийг худалдан авах сонирхолтой иргэдэд урт хугацаат ногоон зээлийн олгох боломжтой. Иргэд энэ технологийг ашигласнаар хуулийн дагуу цахилгаан хөнгөлөлт эдлэх боломжтой таатай нөхцөл үүснэ.

## **V БҮЛЭГ. ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ**

Жил ирэх тусам эдийн засгийн өсөлтөт бизнесүүд нь хүн төрөлхтөн, байгаль орчин хүрээлэн буй нийгэмд томоохон хохирол учруулж байгааг илүү их мэдрэгдэх болсон. ДНБ-ээр тухайн улсын эдийн засгийн өсөлтийг хэмжих нь өрөөсгөл ойлголт болсон ба тогтвортой тэнцвэртэй эдийн засгийн болон нийгмийн өсөлт нь цаашдын хөгжлийн үндэс юм. Тийм ч учраас байгаль орчин, эдийн засаг болон нийгмийн тэнцвэртэй өсөлтийг илүү чухалчлан үзэх болсон ба үүний төлөө дэлхийн бүх улс орнууд тогтвортой хөгжлийн зорилго тавьж ажиллаж байна. Мөн тогтвортой санхүүжилтийн зорилтыг дэмжиж ажилснаар бүхий л оролцогч талуудад нийгэм, байгаль орчин, уур амьсгал, БОНЗ-ын асуудлуудыг нэгтгэх замаар эдийн засаг, санхүүгийн зах зээлийг илүү эрсдэлийг даван туулах чадвартай болон тогтвортой болгож үр дүнгийн хүртэх боломжтой.

Манай орны хувьд байгаль орчин нийгмийн асуудлууд, усны бохирдол, цөлжилт, газар ашиглалт, уур амьсгалын өөрчлөлт, ЖДҮ-ийн санхүүгийн хүртээмж болон агаарын бохирдол гэх мэт олон тогтвортой байдлын асуудалтай тулгарч байна. Үүнээс шалтгаалан манай орон тогтвортой санхүүгийн мэдлэг болон манлайлын төв болох алсын хараат зорилттой ажиллаж байна. 2021 оноос 2030 он хүртэл ТХЗ-уудаа биелүүлэхэд Манай оронд урьдчилсан тооцооллоор 280 их наяд орчим төгрөг шаардлагатай болох юм. Цаашлаад дараагийн 10 жилийн хугацаанд жил бүр 28 их наяд төгрөгийн санхүүжилт шаардагдах ба энэ нь жилийн ДНБ-ий 70 хувьтай тэнцэх хэмжээний санхүүжилт юм. Эдийн засаг болон улсын хөгжилд санхүүгийн салбар том үүрэг хүлээдэг тул уламжлалт ердийн тогтвортой санхүүгээр дамжуулан, уламжлалт болон ердийн бизнес моделийг өөрчлөх нь нийгэм болон байгаль орчны тэнцвэртэй хөгжлийн гол түлхүүр болж байна. Мөн монголын санхүүгийн салбар хүрээлэн буй орчны чанарыг сайжруулах шаардлагаар ногоон зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх хэрэгцээтэй байна. Хэдий Банк нь ногоон зээл олгож байгаа ч шаардлага өндөр, нэр төрөл бага, мөн шаардлагатай салбарын зээл олголтын дээд хэмжээ бага байна. Төрөөс ББСБ илүү олон ногоон зээлийн санхүүжилт хувиарлах шаардлагатай, ББСБ-үүд бусад санхүүгийн байгууллагийг бодоход жижиг бичил бизнес, иргэдэд илүү хүртээмжтэй ажилладаг. Тийм ч учраас санхүүгийн бүх түвшний хүнд ногоон санхүүжилт санал болгож, амьдрах орчноо сайжруулах чин хүсэлтэй хүмүүст хүрч ажиллаж чадах юм.

ББСБ олон улсын сайн дурын сангуудтай хамтран өөрсдийн ногоон зээлийн төрөл, бүтээгдэхүүнийг нэмж илүү иргэдэд хүртээлтэй, ногоон зээл шаардлагатай хэрэгтэй салбарын зээл олгох дээд хэмжээг нэмэх нь зүйтэй. Жишээлбэл манай орны ББСБ-ын ногоон зээлэнд усыг дахин боловсруулж ашиглах, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл, хүлэмжийн хийн ялгаралыг бууруулах, нүүрстөрөгчийг хувиргах гэх мэт



шаардлагатай салбаруудад зээлийн санхүүжилт хувиарлах хэрэгцээтэй байна. Энэ бүгдэд зориулсан олон улсын сангуудтай хамтарч ажиллах хэрэгтэй бөгөөд улсын дэмжлэг нэн шаардлагатай байна. Олон улсын хэмжээнд ногоон зээл болон санхүүжилт олгодог хэд хэдэн сан байна.

Хэрэв ББСБ ногоон таксономи дахь бүх төрлөөр зээлээ олгодог болсноор банкны зарим шаардлагыг хангаж чадахгүй байгаа бичил бизнес болон төслүүдэд санхүүжилтийн томоохон боломж бүрдэх боломжтой. ББСБ-ын зээл олголт хийгдэхгүй байгаа “Сэргээгдэх эрчим хүч”-ний салбарыг сонгон авч шинжилгээгээ хийсэн. Дэлхий дахинаа байгалийн нөөц баялагыг нөхөн сэргээхээс илүү их хурдан хэрэглэж дуусаж байна. Нүүрстөрөгчин ялгаруулалтыг багасгаж сэргээгдэх эрчим хүч ашиглаж эхлэх нь бидний ирээдүйд амьдрах нөхцөлийг илүү сайнаар бүрдүүлж өгч чадна. Байгаль орчинтойгоо нийцтэй амьдархын тулд сэргээгдэх эрчим хүч ашиглах шаардлагатай болж байна. Манай өмнө бүсэд оршдог аль өрх болон бизнесийн нэгжүүдийн сэргээгдэх эрчим хүчийг дэмжсэнээр нүүрсээ хэмнээд зогсохгүй бусад нутагтаа экспортлож өөрсдийн үнэ цэнийг бүтээх боломжтой юм. Манай орны өмнө бүсэд хятадад байгуулагдсан салхин сэнс болон нарны панелийн станцуудын талтай тэмцэх хэмжээний станц өмнөдийн говь цөлд барихад улсынхаа бүх нутаг дэвсгэрийг сэргээгдэх эрчим хүчээр хангаж, цахилгаан станцаа нөөц эрчим хүчний үүсгэвэр болгон ашиглах боломж бий болно.

Сэргээгдэх эрчим хүчний ногоон зээл гаргаснаар ББСБ-нд олон үнэ цэнэ бий болох юм. ББСБ банкнаас илүү бага шалгуур үзүүлэлт, хурдан олголттоороо давуу байдаг. Мөн дэлхийн хэмжээнд ЖДҮ-г хөгжүүлэх, ажилгүйдэл болон ядуурлыг бууруулах бүхий л голлох төсөл хөтөлбөрүүд бичил санхүүгийн байгууллагуудаар дамжин хэрэгжиж ирсэн байдаг та адил аль өрх бүрт сэргээгдэх эрчим хүчний үүсгэвэртэй болоход голлох үүрэг гүйцэтгэх боломжтой. Тэр ч утгаараа энэхүү шинэ салбарын хөгжилд ББСБ үүрэг хүлээж ногоон зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх хэрэгцээ байна гэж үзэж байна.

Манай орон байгалийн нөөц ихтэй орон боловч зүй зохистой хэрэглээний мэдлэг бага ба цахилгаан станц аюултай түвшний заалттайгаар нөөц эрчим хүчгүйгээр ажиллаж байна. Гэтэл дэлхийн дээгүүр ордог сэргээгдэх эрчим хүчний боломжит газарзүйн бүсэд оршиж байна. Манай орон Хятад улсынх шиг хамгийн том цахилгаан станцын нөөцтэй ч ердөө түүний 50 хувийн хэмжээнд сэргээгдэх эрчим хүчний салхин сэнс болон нарны панелийн станц ашиглаж эхлэхэд улсынхаа нийт эрчим хүчний дийлэнхийн хангаж чадахаар хэмжээнд байна. Тийм ч учраас ББСБ олон улсын байгууллагатай хамтрах замаар ногоон зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх арга боломжийг судлан танилцууллаа.

ББСБ өгөх санал зөвлөмж

Ногоон зээл нь олон улсад хурдацтай өсөн хөгжиж буй салбар бөгөөд энэхүү салбарт ББСБ ч гэсэн нөлөөлөл үзүүлж байдаг. ББСБ нь банкны тэр болгон хүрч үйлчилч чаддаггүй харилцагч нарт цаг алдалгүй үйлчилгээ үзүүлж, шийдвэр гаргуулж байдгаараа давуу тал болдог. Энэ бүлэгт хамаарагдах хүмүүс манай оронд их байдаг. Харин

нийтээрээ энэхүү шинэчлэлд орж байж үр дүнтэй болно. Мөн цаашид ББСБ дараах үйл ажиллагаануудыг хийх шаардлагатай гэж үзэж байна.

- Ашиг эрсдэлээ сайн тооцож боловсруулсан байхад ногоон зээлээс ашиг олох боломж үүсэж болно.
- Манай орон сэргээгдэх эрчим хүчний асар том нөөцтэй учир олон улсын байгууллагуудын анхаарлыг татаж, эх үүсвэр болон хөрөнгө оруулалт татах хэрэгтэй.
- Мөн зээлийн бүтээгдэхүүнээ ихэсгэж, хамтрагч байгууллагуудаа нэмэх шаардлагатай байна.

## VI БҮЛЭГ. НОМ ЗҮЙ

### а/ Монгол хэлээр:

- Л.Оюун. (2004).
- Т.Намжин. (2018). Монгол улсын хөгжлийн бодлогын тогтвортой байдал, залгамж чанар, уялдаанд хийсэн шинжилгээ .
- М.Энхжин. (2022). Арилжааны банкин дахь ногоон зээлийн эрсдэлд нөлөөлөгч хүчин зүйлсийн судалгаа .
- Б.Азжаргал. (2019). 3. Арилжааны банкуудын тогтвортой санхүүжилттэй холбогдох үйл ажиллагааг нэмэгдүүлэх нь .
- В.Билгүүдэй. (2021). 2. Иргэдийн ногоон зээлд тавигдах шалгууруудыг багасгах болон ногоон зээлийн талаарх иргэдийн мэдлэгийг тэлэх нь .
- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем . (2007 оны 1 11). *Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль*. <https://legalinfo.mn/mn/detail/465>-ээс Гаргасан
- СЗХ. (2022). *БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА*. Улаанбаатар.
- ХХК, Э. Ж. (2016). Монгол улсын ногоон зах зээлийн судалгаа .
- Эрчим хүчний зохицуулах хороо . (2022 оны 12 15). *ЭХЗХ*. <https://erc.gov.mn/web/mn/news/661>.-ээс Гаргасан
- Эрчим хүчний зохицуулах хороо. (2019 оны 5 29). <https://erc.gov.mn/web/mn/news/284>. Сэргээгдэх эрчим хүчний үнэ дэлхийн зах зээл дээр буурч байгаа ч Монгол улсад нэмэгдэж байна.-ээс Гаргасан
- ОББҮХ. (2021).
- Ногоон зээл, Т. (2021 оны 6 13). (ОББҮХ, Ярилцагч)
- Үндэсний статистикийн хороо. (1995-2004). *Монгол Улсын Статистикийн эмхэтгэл*. Улаанбаатар: Адмон ХХК.
- Сэргээгдэх эрчим хүчний туршлага. (2019 оны 4 4). *ZOLO ZOE*. <https://www.youtube.com/watch?v=vOyGpuKoIQ0>-ээс Гаргасан

### б/Англи болон бусад гадаад хэлээр:

- Allet, M. (2011). Why do microfinance institutions go green?
- Allet, M. (2012). 2. Measuring the environmental performance of microfinance: a new tool. Cost management .
- Allet, M. (2012). Measuring the environmental performance of microfinance: a new tool. Cost management .
- Asian Development Bank. (2020 оны 6 9). *Монгол улсын сэргээгдэх эрчим хүчний баялаг нөөцийг эргэлтэд оруулах нь*. <https://www.adb.org/mn/news/features/unlocking-mongolias-rich-renewable-energy-potential>-ээс Гаргасан
- Bank of America commits \$20 billion to Green lending, n. (огноо байхгүй). climate investment funds . (2022). <https://www.cif.org>-ээс Гаргасан
- ELECTRICITY GENERATION CAPACITY . (огноо байхгүй). *US ENERGY INFORMATION ADMINISTRATION (EIA), RENEWABLE ENERGY AGENCY* . <https://www.eia.gov/outlooks/ieo/>.-ээс Гаргасан
- Energy Sector Management Assistance Program . (2022). <https://esmap.org>-ээс Гаргасан [frc.mn](https://esmap.org). (огноо байхгүй).
- Global Climate Partnership Fund. (2022). <https://www.gcpf.lu/investing-in-renewable-energy-and-energy-efficiency.html>-ээс Гаргасан
- Gonzalez, L. E. (2016). Green microfinance: A new frontier to inclusive financial services .

Hattha Kaksekar limited. (2022). *Hattha kaksekar limited*.

<https://hkl.com.kh/en/detail/view/171/57?ctype=article>.-ээс Гаргасан

Hussain, T. (2018). 3. Green Loan Principles to Guide Environmental and Sustainability finance .

International Finance Corporation. (2020). *Emerging Market Green Bonds Report 2019*.

International Finance Corporation. (2020). *Emerging Market Green Bonds Report 2019*.

Mongolian National Broadcaster . (2019 оны 12 28). *Монгол инженер - Сэргээгдэх эрчим хүч* . <https://www.youtube.com/watch?v=td0nIfwYvSY>.-ээс Гаргасан

Nordea, B. a.

Sean Geoboy, Y. O. (2018). The Impact of Green Lending on Credit Risk in China .

Team, C. (2022 оны 10 13). Corporate finance institute:

<https://corporatefinanceinstitute.com/resources/esg/green-bond/>.-ээс Гаргасан

United Nations Development Program, S. D. (2015).

## ХАВСРАЛТ

### Хавсралт 1 Тогтвортой санхүүжилтийн холбооны түүхэн замнал

5 сар, 2013	Анхны Тогтвортой Санхүүжилтийн Форум
9 сар, 2013	Ажлын хэсгийн анхны уулзалт
11 сар, 2013	Тунхаг бичигт гарын үсэг зурах ёслол
3 сар, 2014	SBN-д албан ёсоор элсэв
1 – 11 сар, 2014	ТоС-ийн зарчмуудыг боловсруулав
11 сар, 2014	ТоС-ийн Удирдах хороог байгуулав
12 сар, 2014	Тогтвортой Санхүүжилтийн Форум 2014
12 сар, 2014	МБХ, БОАЖЯ, Монголбанк, НЗД хооронд хамтын ажиллагааны санамж бичиг байгуулав
1 сар, 2015	ТоС-ийн зарчмуудыг хэрэгжүүлж эхлэв
7 сар, 2015	ТоС-ийн сайн дурын тайлан авдаг болов
11 сар, 2015	Тогтвортой Санхүүжилтийн Форум 2015
11 сар, 2015	Ногоон зээлийн сан төслийг санаачлав
4 сар, 2016	Ногоон зээлийн сангийн ажлын хэсэг байгуулав
7 сар, 2017	ТоС-ийн стандарт сургалтын хөтөлбөр боловсруулж, батлав
11 сар, 2016	Тогтвортой Санхүүжилтийн Форум 2016
9 сар, 2017	Тогтвортой Санхүүжилтийн Форум 2017
9 сар, 2017	МБХ, СЯ, БОАЖЯ, GGGI хооронд хамтын ажиллагааны санамж бичиг байгуулав
12 сар, 2017	ТоС Холбоог байгуулав
3 сар, 2018	Онлайн сургалтын платформ боловсруулах төсөл албан ёсоор нээлтээ хийв
11 сар, 2018	ТоС-ийн үндэсний замын зургийг батлав